



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

***“Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн”-д
хийсэн нийцлийн аудитын тайлан***



***Засгийн газрын тусгай сангийн эрх зүйн зохицуулалт
хангалтгүй байна***

Улаанбаатар хот
2015 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар	Товчилсон үгийн жагсаалт	3
Газрын дарга: Б. Алтанзул	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл.....	4
Аудитын менежер: З.Ариунзаяа	Ерөнхий мэдээлэл.....	5-6
Ахлах аудитор: Ш.Энхтайван	Бүлэг.1 Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.....	7-10
Шинжээч: Д.Эрдэнэцогт Г.Ганбаатар А.Ариунзаяа Ц.Цэрэннамжил	1.1 "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-г Төсвийн тухай хуультай нийцүүлээгүй байна.....	7-8
	1.2 "Соёл, урлаг хөгжүүлэх сан"-гийн дансыг БСШУЯ-ны аппаратын үйл ажиллагааны данстай нэгтгэсэн нь ЗГТСТХ-тай зөрчилдөж байна.....	8-9
	1.3 Дархлаажуулалттай холбоотой үйл ажиллагааг цаашид бусад эрх зүйн актуудын хүрээнд зохицуулах боломжтой байна.....	9
	1.4 "Төслийн сэдэвт ажлын өртөг, зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих асуудлыг зохицуулах журам" батлагдаагүй байна.....	9-10
2015 оны 12 дугаар сар уг тайланг ҮАГ-ын веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn	Бүлэг.2 Сангийн орлогыг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж чадахгүй байна.....	11-14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729 дугаарын утас, 260949 дугаарын факсаар харилцана уу.	2.1 Улсын авто замын санд зөвхөн авто замын хураамжийн орлогыг төвлөрүүлж байна.....	11-12
	2.2 Төсвийн хөрөнгөөс бусад эх үүсвэрээр сангийн хөрөнгийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна.....	12-13
	2.3 Сангийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг бүрэн ашиглаагүй, урьдчилан сэргийлэх тарилга болон сайн дурын дархлаажуулалтын орлогын төлөвлөгөөг тасалсан байна.....	13-14
	2.4 Төсөл, хөтөлбөр хугацаа хоцорч батлагддагаас хөрөнгийн төлөвлөлтийг бодитой төлөвлөж чадахгүйд хүрч байна.....	14
Хаяг: Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160, Монгол улс	Бүлэг.3 Сангийн хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулж байна.....	15-22
	3.1 Орон нутгийн авто замын сангийн хөрөнгийг аймаг, орон нутгийн удирдлага зориулалт бус зүйлд зарцуулж, батлагдсан төсвийг хэтрүүлсэн байна.....	15-16
	3.2 Сангийн хөрөнгөөр хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэхгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.....	17-18
	3.3 Вакцин био бэлдмэлийг худалдан авахад ТБОНӨХБАҮХАТХ-ийн зарим заалтыг мөрдөөгүй байна.....	19-20
	3.4 Төвлөрсөн арга хэмжээний зардлыг эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардлаас санхүүжүүлжээ.....	20-22

Бүлэг.4 Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.....	23-26
4.1 Орон нутгийн авто замын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих нэгж үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.....	23-24
4.2 Хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, зөрүүтэй үнэлсэн зөрчлүүд байна.....	24-25
4.3 Зөвлөл сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	25
4.4 Шинжлэх ухаан технологийн санд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй байна.....	25-26
4.5 Төсвийн ил тод байдлыг хангах, үйл ажиллагаагаа олон нийтэд мэдээлэх, Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж эхэлсэн байна.....	26
Дүгнэлт.....	27
Холбогдох байгууллагын санал.....	28-37
Саналд өгсөн тайлбар.....	38
Зөвлөмж.....	39
Хавсралт.....	40-42
Монгол улсын Ерөнхий аудиторын тушаал.....	43
Монгол улсын Ерөнхий аудиторын тушаалын хавсралт.....	44

Товчилсон үгийн жагсаалт

АТБӨЯХАТ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БТСГ	Биеийн тамир, спортын газар
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ЗГ	Засгийн газар
ЗГТСТХ	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТЯ	Зам тээврийн яам
ИӨТГ	Инноваци, өндөр технологийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МТҮП	Мэдээлэл технологийн үндэсний парк
НАГ	Нийцлийн аудитын газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ССАЖГ	Соёл спорт аялал жуулчлалын газар
ССАЖС	Соёл спорт аялал жуулчлалын сайд
ССАЖЯ	Соёл спорт аялал жуулчлалын яам
СУХС	Соёл, урлаг хөгжүүлэх сан
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШУА	Шинжлэх ухааны академи
ШУБЗГ	Шинжлэх ухааны бодлого зохицуулах газар
ШУТ	Шинжлэх ухаан технологи
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан
ШУТСЗ	Шинжлэх ухаан технологийн салбар зөвлөл
ШУТҮЗ	Шинжлэх ухаан технологийн үндэсний зөвлөл
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМСС	Эрүүл мэнд спортын сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар тодорхойлогдсон "Дархлаажуулалтын сан", "Соёл урлаг хөгжүүлэх сан", "Авто замын сан", "Шинжлэх ухаан технологийн сан"-гийн үйл ажиллагаа, сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд чиглэгдсэн.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- Хууль, эрх зүйн зохицуулалт оновчтой эсэх,
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж, бүрэн бүрдүүлж байгаа эсэх,
- Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх,
- Дотоод хяналт үр нөлөөтэй байгаа эсэх,
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх.

Хамарсан хүрээ

Аудитад ЭМЯ, БСШУЯ, ЗТЯ, ЭХЯ, БХБЯ, "Дархлаажуулалтын сан", "Соёл, урлаг хөгжүүлэх сан", "Авто замын сан", "Шинжлэх ухаан технологийн сан" болон холбогдох харьяа байгууллага, төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд, аймаг, нийслэлийн авто замын сангууд хамрагдлаа.

ТБХ-ны 2014 оны 20 дугаар тогтоолоор баталсан аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу 6 санд аудит хийхээс УИХ-аас ЗГТСТХ-д оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хасагдсан "Орон сууц хөгжүүлэх сан", "Сэргээгдэх эрчим хүчний сан"-г аудитад хамруулаагүй болно.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандартыг ашиглалаа.

Аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн шалгах, мэдээллийн эх үүсвэртэй тулган баталгаажуулав.

Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандартад заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ерөнхий мэдээлэл

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль УИХ-аар 2006 онд батлагдсанаас хойш 8 удаа нэмэлт өөрчлөлт орсноор 2015 онд 12 санг татан буулгаж өнөөдрийн байдлаар 26 сан үйл ажиллагаа явуулж байна.

Авто замын сан

Авто замын сангийн үйл ажиллагааг 1998 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр батлагдсан Авто замын тухай хууль, 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-аар зохицуулж байна.

Хуулийн дагуу 1998 онд Улсын авто замын сан, 1998-2000 онуудад нийслэл, аймгуудад Орон нутгийн авто замын сангууд тус тус байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Улсын авто замын сан нь Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төвийн бүтцэд харьяалагддаг 15 төлбөр хураах цэгээр дамжуулан олон улсын болон улсын чанартай авто замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зохих хураамжийг авч улсын төсөвт төвлөрүүлж байна. 2014 оны Төсвийн тухай хуулиар тус сан 2.35 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 2.9 тэрбум төгрөг төвлөрүүлж, 962.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

Соёл, урлаг хөгжүүлэх сан

СУХС нь үндэсний соёл, урлагийг хөгжүүлэх, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах, соёлын үйлчилгээг өргөжүүлэх, соёл, урлагийн ажилтны мэргэшлийг дээшлүүлэх, уран бүтээл туурвих, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, соёлын салбарт хөрөнгө бүрдүүлэлт, хандив, буцалтгүй тусламж үзүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах, соёлын үнэт зүйлсийг уламжлах, түгээн дэлгэрүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор Засгийн газрын 1998 оны 40 дүгээр тогтоолоор байгуулагдсан.

Засгийн газрын 2012 оны 48 дугаар тогтоолоор СУХС-гийн Ажлыг албыг байгуулж, орон тооны хязгаарыг 9 хүнээр баталсан ба Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 2015 оны нэмэлт өөрчлөлтөөр Ажлын албыг татан буулгасан байна.

УИХ-аас 2014 онд СУХС-гийн нийт төсвийг 5.04 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 3.82 тэрбум төгрөг, үүнээс 3.66 тэрбум төгрөгийг хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан байна.

Дархлаажуулалтын сан

Дархлаажуулалтын сан улсын хэмжээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, био бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл бэлтгэх, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах, дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бэлтгэх зорилгоор Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолоор байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Дархлаажуулалтын үйл ажиллагаанд 2014 онд 7.04 тэрбум төгрөг төлөвлөснөөс нийт 6.87 тэрбум төгрөг төвлөрүүлж 3 төрлийн вакцин, 14 төрлийн био бэлдмэл, 3 төрлийн эмнэлгийн хэрэгслийг 3.92 тэрбум төгрөгөөр, 8 төрлийн үндэсний товлот вакцин, 3 төрлийн эмнэлгийн хэрэгслийг 2.93 тэрбум төгрөгөөр тус тус бэлтгэн Ажлын

албаны зардалд 10.7 сая төгрөг зарцуулан төсвийн ашиглагдаагүй үлдэгдэл болох 2.5 сая төгрөгийг Сангийн яаманд буцаан шилжүүлжээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоолоор Дархлаажуулалтын сан болон Ажлын албыг татан буулгаж, дархлаажуулалттай холбоотой бүх гүйлгээг ЭМЯ-ны аппаратын үйл ажиллагааны дансаар дамжуулан гүйцэтгэх болсон бөгөөд сангийн үйл ажиллагааг ЭМЯ-ны тухайн чиг үүргийг хариуцсан газар хэлтэст харьяалуулсан байна.

Шинжлэх ухаан, технологийн сан

Засгийн газрын 1993 оны 192 дугаар тогтоолоор Шинжлэх ухаан, технологийн сан байгуулагдаж, батлагдсан дүрмийн дагуу 1994 оны 4 дүгээр сараас 6 хүний орон тоотойгоор онолын суурь судалгаа, шинжлэх ухаан, технологийн төслийг хэрэгжүүлэх, түүний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, санхүүжүүлэх, зарцуулсан хөрөнгийн ашиглалтад хяналт тавих, нэгтгэн тайлагнах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж эхэлсэн байна.

ШУТС Шинжлэх ухаан технологийн тухай хууль, БСШУС-ын 2008 оны 379 дүгээр тушаалаар баталсан Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрмээр үйл ажиллагаагаа зохицуулж, Санхүү, удирдлагын хэлтэс, Төслийн мониторингийн хэлтэс, Оюуны сан-мэдээллийн хэлтэс, Шинжлэх ухааны паркийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах Ажлын алба гэсэн дөрвөн нэгж, 22 ажилтантай ажилласан байна.

ШУТС ЗГ-ын 2015 оны 27 дугаар тогтоолоор нэгтгэн зохион байгуулсан 23 хүрээлэнд санхүүжилт олгожээ.

Тус санд 2014 онд 26.5 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 26.1 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 0.4 тэрбум төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлж, 8.4 тэрбум төгрөгийг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд, 18.1 тэрбум төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

БҮЛЭГ 1 ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

1.1 Авто замын сан

"Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ыг Төсвийн тухай хуульд нийцүүлээгүй байна.

Авто замын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1¹, 18.2²-т Улсын авто замын сан, Орон нутгийн авто замын сан гэж 2 ангилсан тодорхойлолтыг тусгасан бөгөөд ЗГТСТХ-д зөвхөн Улсын авто замын сангийн зохицуулалтыг тусгаж, Орон нутгийн авто замын сангийн эрх зүйн зохицуулалт тодорхой тусгагдаагүй байна.

"Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-д 1998 оноос хойш өөрчлөлт ороогүй бөгөөд энэхүү журамд заасан байгууллагууд нь Засгийн газарт хийгдсэн удаа дараагийн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд өөрчлөгдсөн, эрх үүрэг нь хаашаа очсон нь тодорхойгүй болсон, мөн төсвийн болон салбарын хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх шийдвэрийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн гаргаагүй байгаа зэрэг Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4³, 24.2⁴ дахь заалтын хэрэгжилтийг хангаагүй болохыг харуулж байна. Тухайлбал:

Журмын 2.3-т "... авто замын сангийн дансыг нээхдээ Сангийн яам, Авто замын газар болон уг дансыг байршуулах арилжааны банк хоорондоо талуудын эрх, үүргийг тодорхой заасан гэрээг тухай бүр байгуулна, 3.6-д "... хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг Авто замын газар ... боловсруулж Дэд бүтцийн хөгжлийн яаманд жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ", 3.10-т "... зам, замын байгууламжийг барих гүйцэтгэгчийг шаардлагатай тохиолдолд Барилга, архитектурын газар сонгон шалгаруулалт явуулан сонгож, гэрээ байгуулан түүний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг Авто замын газар... хариуцна" гэж заасан байхад Авто замын газар, Дэд бүтцийн хөгжлийн яам, Барилга, архитектурын газрууд нь үйл ажиллагаа явуулдаггүй, тэдгээрийн гүйцэтгэж байсан үүргүүд нь бусад газарт шилжсэн буюу татан буугдсаныг хуульд нийцүүлэн өөрчлөөгүй байна.

Мөн журмын заалтууд нь бусад хууль, тогтоомжтой нийцэхгүй байна. Тухайлбал:

Журмаар сангийн харилцах дансыг арилжааны банкинд нээхээр зохицуулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.41⁵, ЗГТСТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.7⁶-д заасантай нийцээгүй;

¹ "Улсын авто замын сан нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон нутгийн авто замын сан нь аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд байна",

² "Улсын авто замын сангийн хөрөнгө нь улсын төсвийн, орон нутгийн авто замын сангийн хөрөнгө нь аймаг, нийслэлийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болох бөгөөд түүнийг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, гүйцэтгэлийн тайлан мэдээ гаргах ажиллагааг тухайн төсвийн нэгэн адил журмаар хэрэгжүүлнэ",

³ хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн байгууллага, албан газрын бүтэц, дүрмийг баталж, дарга /эрхлэгч, захирал/-ыг томилж, чөлөөлнө

⁴ Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана.

⁵ "төрийн сангийн нэгдсэн данс" гэж "Засгийн газрын нэгдсэн зохицуулалт бүхий төсвийн ерөнхий данс болон Монгол Улсын нэгдсэн төсөвт хамаарах бүх төсвийн захирагчийн Монголбанкинд байрших мөнгөн хөрөнгийн харилцах дансыг хэлнэ"

⁶ Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 5.4.10, 5.4.6, 5.4.32-т зааснаас бусад тусгай сангийн хөрөнгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулна.

- Журмын 11 дүгээр заалт нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2⁷, ЗГТСТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1⁸ дэх заалттай нийцээгүй;
- ЗГ-ын 2014 оны 55 дугаар тогтоолын дагуу орон нутаг дахь Тээвэр, авто замын газар татан буугдсанаар Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.

Иймд Авто замын тухай хууль, улсын болон орон нутгийн авто замын сангийн үйл ажиллагааг зохицуулж буй журмуудыг Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

1.2 Соёл, урлаг хөгжүүлэх сан

“Соёл, урлаг хөгжүүлэх сан”-ийн дансыг БСШУЯ-ны аппаратын үйл ажиллагааны данстай нэгтгэсэн нь ЗГТСТХ-тай зөрчилдөж байна

СУХС Монгол Улсын Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Монгол Улсын Соёлын тухай хууль, Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, ССАЖС-ын 2012 оны А/24 дүгээр тушаалаар батлагдсан “Соёл, урлаг хөгжүүлэх сангийн дүрэм”-ийн хүрээнд 2014 онд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоолын дагуу хийсэн бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан тус сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан ССАЖС-ын 2012 оны А/24 дүгээр тушаалаар батлагдсан СУХС-ийн дүрмийг БСШУС шинэчлэн батлаагүй нь Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4⁹ дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Сангийн үйл ажиллагаанд 2014 онд мөрдөгдсөн дээрх дүрмийн 5.1-д Ерөнхий менежер “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан нь Төсвийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1¹⁰ дэх заалттай нийцэхгүй байна.

Мөн сангийн орлого зарлагын гүйлгээг БСШУЯ-ны аппаратын үйл ажиллагааны дансаар дамжуулан гүйцэтгэх болсон нь ЗГТСТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1¹¹ дэх заалтыг зөрчиж байна.

ССАЖС-ын 2013 оны А/143 дугаар тушаалаар “Соёл, урлагийн салбарт хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төслийг хүлээн авах шийдвэрлэх журам”-ыг баталж, зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилсон ба Зөвлөл 2014 онд нэг удаа хуралдаж тус онд хэрэгжүүлэх 104 төсөл, арга хэмжээнээс 17 төсөл хөтөлбөрийг хэлэлцсэн, өөр хуралдаан зохион байгуулаагүй байна. Энэ нь журмын 3.4-т “соёл, урлагийн салбарт хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ, арга хэмжээ гүйцэтгэх төслийг улирал бүрийн нэгдүгээр долоо хоногт багтааж Зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй болохыг харуулж байна.

⁷ Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна.

⁸ Төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай сангийн зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан тайланд тусган санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

⁹ хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн байгууллага, албан газрын бүтэц, дүрмийг баталж, дарга /эрхлэгч, захирал/-ыг томилж, чөлөөлнө

¹⁰ Энэ хуулийн 71.2, 71.3-т зааснаас бусад заалтыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

¹¹ “Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 5.4.10, 5.4.16, 5.4.32-т зааснаас бусад тусгай сангийн хөрөнгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулна”

Дээрх журамд сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг Зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлах тухай нарийвчилсан заалт байхгүй, сангийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журам бүрэн зохицуулж чадахгүй байна.

1.3 Дархлаажуулалтын сан

Дархлаажуулалттай холбоотой үйл ажиллагааг цаашид бусад эрх зүйн актуудын хүрээнд зохицуулах боломжтой байна

Вакцинжуулалт, урьдчилан сэргийлэх тарилгатай холбоотой төлөвлөлт болон технологийн ажиллагааг Дархлаажуулалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, “Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллол” батлах тухай Засгийн газрын 2009 оны 185 дугаар тогтоол, “Вакцин био бэлдмэлийг хүлээн авах, тээвэрлэх, хадгалах явцад баримтлах журам”, “Задалсан вакциныг хэрэглэх журам” батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2011 оны 122 дугаар тушаал, “Вакциныг төлөвлөх, нөөцлөх, бүртгэх журам”, “Вакцинжуулалтын явцад баримтлах хүйтэн хэлхээний журам”, “Вакцины хүйтэн хэлхээний байнгын үйлчилгээ хяналтын журам” батлах тухай 1997 оны 219 дүгээр тушаалуудаар батлагдсан журмын хүрээнд зохицуулж байна.

Дархлаажуулалтын сантай холбоотой үйл ажиллагааг 2001 онд Засгийн газрын 67 дугаар тогтоолоор батлагдсан “Дархлаажуулалтын сангийн ажиллах журам”, “Дархлаажуулалтын сангийн зөвлөлийн дүрэм”-ээр зохицуулж ирсэн боловч энэхүү журмуудын холбогдох заалтууд хоорондоо болон бусад хууль тогтоомжтой зөрчилдсөнөөс Сан бие даан шийдвэр гаргахад хүндрэлтэй болсон байна. Тухайлбал:

- “Дархлаажуулалтын сангийн ажиллах журам”-ын 4 дэх заалтад сангийн шууд захирагчийн үүргийг сангийн зөвлөлийн зохицуулалт дор ХӨСҮТ гүйцэтгэхээр, 3 дахь заалтад “Дархлаажуулалтын сан” нь бие даасан хуулийн этгээд байна гэж, “Дархлаажуулалтын сангийн зөвлөлийн дүрэм”-ийн 5 дахь заалтаар Сангийн зөвлөлийн ажлын албаны үүргийг Халдварт өвчин судлалын үндэсний төв гүйцэтгэнэ гэж тус тус заасан;
- Сан нь хуулийн этгээд биш тул албан ёсны шийдвэр гаргах боломжгүй Сангийн зөвлөлийг дэд сайд ахлан хуралдаж хурлын тэмдэглэлээр үүрэг өгдөг бөгөөд эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр ЭМЯ-ны ТНБД уг сангийн төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж яамны тамга, тэмдгээр санхүүгийн баримтуудыг баталгаажуулж иржээ.

ЗГТС-ийн тухай хуульд 2015 оны 1 дүгээр сард орсон өөрчлөлтөөр “Дархлаажуулалтын сан”-г татан буулгасан хэдий ч хуулийн өөрчлөлттэй холбоотой хүчингүй болгосон эрх зүйн актуудад цаашид мөрдөх боломжгүй болсон дээрх тогтоолыг хамруулаагүй байна.

1.4 Шинжлэх ухаан, технологийн сан

“Төслийн сэдэвт ажлын өртөг, зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих асуудлыг зохицуулах журам” батлагдаагүй байна

ШУТС нь харьяа байгууллагуудын 2014 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулиар батлагдсан цаглабаруудын дагуу хянаж нэгтгэн БШУС-д хүргүүлж ажилладаг бөгөөд эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэнгүүд, их сургууль, ШУА, харьяа байгууллагуудын хөтөлбөр, үр дүнгийн гэрээг дүгнэх эрхийг ЗГ-ын 2014 оны 135 дугаар тогтоолд заасны дагуу хэрэгжүүлж байна.

“Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ыг ЗГ-ын 2014 оны 301 дүгээр тогтоолоор шинэчлэн баталжээ.

Дээрх шинэчилсэн журмын 6.8-д *"Төслийн сэдэвт ажлын өртөг, зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих асуудлыг зохицуулах журмыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална"* гэсний дагуу журам гаргаагүй нь БСШУС Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2¹² дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Сангийн захирал Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3¹³, БСШУС-ын 2008 оны 379 дүгээр тушаалаар баталсан *"Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрэм"*-ийн 2 дугаар зүйлийн 2.1¹⁴ дэх заалтыг зөрчиж бүтэц зохион байгуулалтын тухай тушаал гаргасан нь Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4¹⁵-д заасан Засгийн газрын гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлэн эрх мэдлээ хэтрүүлсэн байна.

Салбар зөвлөлөөр дэмжигдсэн захиалагчийн санал, төслийн сэдвийг ШУТҮЗ хуралдаанаар хэлэлцээгүй, сангийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, суурь судалгааны зардлын эрдэм шинжилгээний ажлын нийт зардалд эзлэх хувь хэмжээг тогтоож өгөөгүй нь ШУТС-ийн дүрмийн 2.2 дахь заалтыг Үндэсний зөвлөл биелүүлж ажиллаагүй болохыг харуулж байна.

ШУТСЗ-ийн 2014 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар ЗГ-ын захиалгаар 2014 оноос эхлэн хэрэгжүүлэх ШУТ-ийн төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэснийг БШУС-ын 2014 оны А/262 тоот *"ШУТ-ийн төсөл батлах тухай"* тушаалаар баталсан нь Шинжлэх ухаан, технологийн төсөл, ажил хэрэгжүүлэх журмын 2.3¹⁶-д заасантай нийцээгүй байна.

ЗГ-ын 2014 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан *"ШУТ-ийн төсөл хэрэгжүүлэх журам"*-ын 7.1-д *"Төслийн арга зүйн түвшин, хэрэгжилтийн явц, хугацаа, үр дүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн байдал, санхүүгийн үйл ажиллагаанд эрх бүхий байгууллага хяналт тавина. Хяналтын зардал нь төслийн нийт зардлын нэг хувиас хэтрэхгүй байна"* гэсэн заалт нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1¹⁷, 69.3¹⁸ заалтуудад нийцээгүй ба БСШУЯ-ны дотоод хяналтын алба нь 2014 онд хяналт тавьж ажиллаагүй байна.

¹² Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана.

¹³ батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;

¹⁴ "... сангийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг Засгийн газар тогтооно"

¹⁵ хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн байгууллага, албан газрын бүтэц, дүрмийг баталж, дарга /эрхлэгч, захирал/-ыг томилж, чөлөөлнө;

¹⁶ "...3 дугаар сард багтаан төсөл, хөтөлбөрийг шалгаруулах"

¹⁷ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

¹⁸ Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.

БҮЛЭГ 2 САНГИЙН ОРЛОГЫГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ БҮРЭН БҮРДҮҮЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

2.1 Авто замын сан

Улсын авто замын санд зөвхөн авто замын хураамжийн орлогыг төвлөрүүлж байна

Улсын авто замын санд төвлөрүүлэх 8 төрлийн орлогоос зөвхөн авто замын хураамжийн орлогыг төвлөрүүлж байгаа ба улсын болон олон улсын чанартай авто зам, авто замын байгууламж барих, засварлах үйл ажиллагааг УИХ-аас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу ЗТЯ-наас зохион байгуулж байна.

Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан 8 төрлийн эх үүсвэрээс 2014 онд АТБӨЯХАТ-аас Орон нутгийн авто замын санд 29.5 тэрбум төгрөг, авто зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс авах төлбөр 2.9 тэрбум төгрөгийг улсын авто замын санд, 6.5 тэрбум төгрөгийг орон нутгийн авто замын санд төвлөрүүлж бусад эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлээгүй байна.

Харин 2014 оны төсвийн тухай хуулиар авто зам, гүүр барих, түүний засвар арчлалтад 285.5 тэрбум төгрөг баталж зарцуулсан ба авто бензин, дизелийн түлшний албан татвар 11.6 тэрбум төгрөгийг улсын төсвийн орлогод төвлөрүүлсэн байна.

Сангийн яам журмын 4.14-д заасны дагуу авто бензин, дизель түлшний албан татварыг 3 хоногт багтааж ЗГ-ын шийдвэрийн дагуу авто замын санд төвлөрүүлж байгаагүй, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг тус санд төвлөрүүлдэггүй төсвийн тухай хуулиар зохицуулдагаас үзэхэд улсын авто замын сангийн үйл ажиллагаа, санхүүжилтийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой болгох шаардлагатайг харуулж байна.

Мөн Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д зааснаар орон нутгийн авто замын сангийн орлого нь АТБӨЯХАТ, Орон нутгийн зам ашигласны төлбөр, Улсын болон орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө, Зээл, тусламж, хандивын орлого, хууль зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийн тодорхой хувь, хэмжээ гэсэн 5 эх үүсвэрээс бүрдэхээр тусгасан боловч зөвхөн АТБӨЯХАТ, орон нутгийн зам ашигласны төлбөрийг төвлөрүүлж байгаа бөгөөд бусад 3 төрлийн орлогыг төвлөрүүлэхэд аймаг, орон нутгийн удирдлагууд анхаарч ажиллаагүй байна.

Дээрх 2 төрлийн орлогыг төвлөрүүлэхдээ орлогыг бүрэн төвлөрүүлдэггүй, дутуу төлөвлөх зэрэг асуудлыг аймаг, орон нутгийн удирдлагууд түгээмэл гаргаж байгаа нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.а¹⁹, 29.1.1.е²⁰, Авто замын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2²¹, Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4.1²², 31.4.6²³-д заасныг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

¹⁹ нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

²⁰ нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах.

²¹ Улсын авто замын сангийн хөрөнгө нь улсын төсвийн, орон нутгийн авто замын сангийн хөрөнгө нь аймаг, нийслэлийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болох бөгөөд түүнийг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, гүйцэтгэлийн тайлан мэдээ гаргах ажиллагааг тухайн төсвийн нэгэн адил журмаар хэрэгжүүлнэ.

²² төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо

²³ төсвийг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын тооцоо

- Булган аймгийн 2014 төсвийн төсөлд зам ашигласны төлбөр хураамжийн орлогыг төлөвлөгөөнд тусгаагүй; Дархан-Уул аймаг зам ашигласны хураамжийн 148.4 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн; Дорноговь аймгийн ИТХ нь 2014 замын хураамжийн орлого 27.7 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгаагүй; Увс аймаг 2014 онд мөн замын хураамжийн орлогыг төлөвлөөгүй байна.;
- Мөн Орхон аймгийн Төрийн сан нь АТБӨЯХАТ-ын орлого 696.5 сая төгрөгөөс төлөвлөгөөгөөр батлагдсан 617.5 сая төгрөгийг автозамын санд төвлөрүүлсэн; Сэлэнгэ аймагт АТБӨЯХАТ 561.6 сая төгрөг төвлөрүүлсэн боловч орон нутгийн авто замын санд 413.4 сая төгрөгийг хуваарилсан байна.

Орон нутгийн авто замын санд төвлөрүүлж буй орлогын 80 орчим хувийг АТБӨЯХАТ-аас, үлдэх 20 орчим хувийг авто зам, авто замын байгууламж ашигласны төлбөрөөс бүрдүүлж буй бөгөөд татвар, хураамжийн бааз суурийг өргөтгөснөөр орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна. Тухайлбал:

- ЗТЯ-ны бүртгэл мэдээллийн санд 2014 онд бүртгэгдсэн 3392 тээврийн хэрэгслийг ТЕГ-ын мэдээллийн санд бүртгэгдээгүйгээс тэдгээрт ногдуулах 187.1 сая төгрөгийн татвар ногдуулж, төвлөрүүлэх боломжийг алдсан; ЗТЯ, ТЕГ-т бүртгэлтэй 154,237 тээврийн хэрэгсэлд Нийслэл, дүүргийн татварын газар татварын ногдуулалт хийгээгүй, тэдгээрээс ашиглагдаж байгаа болон тухайн онд татвараа төлөөгүй 38,925 тээврийн хэрэгслийн татварт ногдох 1,873.6 сая төгрөгийн орлогыг алдсан; Баянхонгор аймгийн татварын хэлтэст бүртгэлтэй 8447 тээврийн хэрэгсэлээс 8073 нь татвараа төлж, хөдөөгийн малчдын 374 нь хамрагдаагүй; Авто замын сангийн журамд АТБӨЯХАТ-аас санд төвлөрүүлэх хувь хэмжээ тодорхойгүй шалтгаанаар Дорнод аймгийн авто замын санд орлого төвлөрүүлээгүй байна.

Иймд сангийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулж түүнд төвлөрүүлэх орлогыг тодорхой болгох, орлогын төлөвлөлтийг сайжруулснаар сангийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.2 Соёл, урлаг хөгжүүлэх сан

Төсвийн хөрөнгөөс бусад эх үүсвэрээр сангийн хөрөнгийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна

ЗГТСТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасны дагуу СУХС нь эх үүсвэрийнхээ зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлдэг байна. Сангийн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1 /сая.төг/

Он	Төсвийн төсөл	Батлагдсан	Тодотгол	Гүйцэтгэл
2014	7,346.8	5,700.0	5,041.9	3,829.3

Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг ЗГТСТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1²⁴, 15 дугаар зүйлийн 15.1²⁵, ССАЖС-ын 2012 оны А/24 дүгээр тушаалаар батлагдсан СУХС-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1²⁶-д тус тус тодорхойлсон байна.

²⁴ Энэ хуулийн 6.1.3-т заасан тусгай сан нь дараахь нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ:

7.1.1. улсын төсвийн хөрөнгө;
7.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;
7.1.3. гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар олгосон зээл.

²⁵ Соёл, урлаг хөгжүүлэх сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

15.1.1. соёл, урлаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр зохион байгуулсан урлагийн тоглолт, уран бүтээлийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн үзэсгэлэнгийн орлого;
15.1.2. гадаад улсад зохион байгуулсан урлагийн тоглолт, уран бүтээлийн болон түүх соёлын

дурсгалт зүйлийн үзэсгэлэн, тэдгээртэй адилтгах арга хэмжээнээс олсон орлого.

²⁶ Сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ.....

СУХС төсвийн санхүүжилтээс бусад эх үүсвэрээс олох орлогыг төлөвлөдөггүй, орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулалгүй ЗГТСТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тус сан 2014 онд гүйцэтгэлээр 3,829.3 сая төгрөг зарцуулснаас улсын төсвөөс 99 хувь буюу 3,797.3 сая төгрөгийн санхүүжилт авч, 1 хувь буюу 31.9 сая төгрөгийн орлогыг урлагийн тоглолт, дурсгалт зүйлийн үзэсгэлэнгийн орлогоос олсон байна.

СУХС-ийн дүрмийн 4.1-д “сангийн хөрөнгө нь өөрийн болон гадаад оронд зохион байгуулсан урлагийн тоглолт, үзэсгэлэнгийн орлого зэргээс бүрдэнэ” гэж заасан боловч орлогын хэдэн хувийг санд эргэн төвлөрүүлэх талаар нарийвчлан тусгаагүй байна. Тухайлбал:

- 2014 онд СУХС-аас байгуулсан “Ажил, арга хэмжээ гүйцэтгэх” 9 гэрээнд тоглолтын орлогоос нийт 20.3 сая төгрөгийг санд эргэн төвлөрүүлэхээр тусгасан бөгөөд гүйцэтгэгч байгууллагууд гэрээнд заасан хугацаандаа 7.9 сая төгрөгийг төвлөрүүлж, сангаас гэрээнд заасан санхүүжилтийг дутуу олгосноос 5.0 сая төгрөг, гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалж 7.4 сая төгрөг нийт 12.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломжийг алдсан;

2.3 Дархлаажуулалтын сан

Сангийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг бүрэн ашиглаагүй, урьдчилан сэргийлэх тарилга болон сайн дурын дархлаажуулалтын орлогын төлөвлөгөөг тасалсан байна

Сангийн орлогыг 2013-2015 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг болон төсвийн эх үүсвэрээр бэлтгэсэн вакциныг ашиглан сайн дурын дархлаажуулалт, урьдчилан сэргийлэх тарилгын орлогоор бүрдүүлэхээр төлөвлөж иржээ.

Сайн дурын дархлаажуулалт болон урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдахаар аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт захиалга өгсөн аж ахуйн нэгж байгууллагуудын захиалгыг ХӨСҮТ-д нэгтгэх замаар төсвийн төлөвлөлтийг хийж байгаа нь бодитой бус байна.

ЭМЯ, Дархлаажуулалтын сан, ХӨСҮТ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрууд нь урьдчилан сэргийлэх тарилга болон сайн дурын дархлаажуулалтанд ажилтнуудаа заавал хамруулах шаардлагатай байгууллагуудын судалгаанд үндэслэн төлөвлөлтийг хийдэггүй, түүнийг өргөжүүлэх талаар үйл ажиллагаа явуулдаггүй нь Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1²⁷, 9 дүгээр зүйлийн 1²⁸ дэх зарчмыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Үүнээс шалтгаалан Дархлаажуулалтын сангийн ажиллах журмын 6.б²⁹, 6.в³⁰, 6.г³¹ заалтад тусгагдсан төсвийн бус эх үүсвэрээс сангийн орлогыг бүрдүүлэх боломжийг алджээ. Тухайлбал:

- Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Завхан, Орхон, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хэнтий зэрэг 13 аймаг сайн дурын дархлаажуулалтын төлөвлөлтийг хийгээгүй, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив тусламжаар орлого

²⁷ Дархлаажуулалтын ажлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагууд зохион байгуулна.

²⁸ Дархлаажуулалтын ажлын төлөвлөлт, халдварт өвчнөөс сэргийлэх, тархалтыг тандах, өвчлөл гарсан үед тархалтыг хязгаарлах, таслан зогсоох үйл ажиллагааг халдварт өвчинтэй тэмцэх мэргэжлийн төв байгууллага /цаашид "халдварт өвчин судлалын төв байгууллага" гэх/ зохион байгуулна.

²⁹ Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив тусламж

³⁰ Гадаад орон, олон улсын болон сайн дурын байгууллагын хандив тусламж

³¹ Сайн дурын дархлаажуулалт болон сэргийлэх тарилгын орлого

бүрдүүлэх талаар сангаас 2014, 2015 оны төсвийн төсөлд тусгаагүй; гадаад орон, олон улсын болон сайн дурын байгууллагын хандив тусламжаар, орлого бүрдүүлэх талаар 2014, 2015 оны төсвийн төсөлд тусгаагүй төдийгүй хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж, вакцины үнийн хөнгөлөлтөөрх орлого зэрэг зайлшгүй орох орлогуудыг сангийн зүгээс төлөвлөж төсөвт тусгаагүй байна.

Дархлаажуулалтын санд 2014 онд төвлөрүүлсэн орлогыг 2013 онтой харьцуулбал 6,712.1 сая төгрөг буюу 5.6 сая төгрөгөөр буурснаас сайн дурын дархлаажуулалт буюу урьдчилан сэргийлэх тарилгын орлого 163.7 сая төгрөг буюу 2013 оноос 103.5 сая төгрөгөөр тасарсны нэг шалтгаан нь төлөвлөлт хийж байсан үе шат болох 2013 онд “А” гепатитын дархлал сэргээх нэмэлт дархлаажуулалтыг нийт хүмүүст төлбөртэй хийж байсан бол ЭМС-ын 2012 оны 357 дугаар тушаалаар 1 нас 2 сартайгаас 2 настай хүүхдэд үнэ төлбөргүй хийх болсонтой холбоотой байна.

2.4 Шинжлэх ухаан, технологийн сан

Төсөл, хөтөлбөр хугацаа хоцорч батлагддагаас хөрөнгийн төлөвлөлтийг бодитой төлөвлөж чадахгүйд хүрч байна

ЗГ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “ШУТ-ийн төсөл, ажил хэрэгжүүлэх журам”-ын 19–д *“ШУТСЗ нь төслийн захиалгын саналыг эрдэмтэд, захиалагчийн төлөөллийг оролцуулан 5 дугаар сард багтаан хэлэлцэж сонгоно”* гэж заасны дагуу 2013 онд төслүүдийн сонгон шалгаруулалт хугацаандаа хийгдээгүй нь 2014 оны төсвийн төслийг үндэслэлтэй төлөвлөхгүй байх нэг үндэс болж байна.

2014 онд ШУТС-ийн туслах үйл ажиллагааны орлого 23.0 сая төгрөгөөр тасарсан нь СЯ орлогын төлөвлөгөөг өсгөсөн, ШУТС-ийн харъяа эрдэм шинжилгээний төв, хүрээлэнгүүд орлогоо үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Мөн тус онд улсын төсвийн санхүүжилт 1,203.8 сая төгрөгөөр тасарсан нь төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалжээ.

Шинжлэх ухаан технологийн сангийн эх үүсвэрийн дийлэнхийг зөвхөн улсын төсвөөс бүрдүүлж, ШУТ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1³²-д заасан бусад эх үүсвэрийг бүрэн ашиглахгүй байна.

³² Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг дор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 14.1.1.улсын төсвөөс олгосон хөрөнгө;
- 14.1.2.орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө;
- 14.1.3.гадаад улс, олон улсын байгууллагаас олгосон хөрөнгө;
- 14.1.4.гадаад улсын болон Монгол Улсын иргэн, байгууллага, хуулийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламж;
- 14.1.5.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

БҮЛЭГ 3 САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛЖ БАЙНА

3.1 Авто замын сан

Орон нутгийн авто замын сангийн хөрөнгийг аймаг, орон нутгийн удирдлага зориулалт бус зүйлд зарцуулж, батлагдсан төсвийг хэтрүүлсэн байна

Аймгийн ИТХ Авто замын сангийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³³, 67 дугаар зүйлийн 67.1³⁴-д заасныг зөрчиж, зураг, төсөв, ТЭЗҮ нь бэлэн болоогүй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгадаг дутагдал нийтлэг байна. Тухайлбал:

- Баянхонгор, Дорнод аймгийн ИТХ нь авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлаагүй байна.

Орон нутгийн авто замын санд 2014 онд төвлөрүүлсэн 36.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-д заасны дагуу зам, замын байгууламжийн өргөтгөл, шинэчлэл, арчлалтын ажилд зарцуулж буй боловч ЗГТСТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5³⁵, 22 дугаар зүйлийн 22.1³⁶ дахь заалт болон дээрх журмын 4, 8 дахь заалтыг зөрчиж зориулалт бус зүйлд зарцуулах, батлагдсан төсөв хэтрүүлэх зөрчлийг гаргасан байна. Тухайлбал:

- Баянхонгор аймгийн ИТХ-ын 2014 оны 39, 66, 97 дугаар тогтоолуудад "Нөөц" гэсэн нэрээр тодорхойгүй зардал баталсан; Булган аймгийн ИТХ нь Авто замын сангийн хөрөнгөөс Булган аймгийн Цагдаагийн газарт 8.2 сая төгрөг, Засаг даргын 2014 оны А/101 тоот захирамжаар АТБӨЯХ-ийн наалтын үнэнд 1.5 сая төгрөг, нийт 9.7 сая төгрөгийг зарцуулсан; Говь сүмбэр Аймгийн ИТХ-ын 2013 оны 6 дугаар тогтоолоор баталсан аймгийн төвийн автозамыг засварлах ажлын төсвийг 64.9 сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэгч "Грейтроуд" ХХК-тай 67.6 сая төгрөгөөр гэрээ байгуулж ажилласнаар төсвийг 2.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан; Завхан аймаг Орон нутгийн автозамын сангийн хөрөнгөнөөс "Барилгын хөгжлийн төв"-д барилгын зураг магадлалын үнэд 1.6 сая төгрөгийг, Аймгийн ГХБХБГ-т барилгын материалын сорил шинжилгээний лаборатори ажиллуулах ажлын хөлсөнд 3.0 сая төгрөг, "Буурь хөрс" ХХК-д барилгын талбайн зураг магадлалын үнэд 9.0 сая төгрөг олгожээ.

Төсөл хөтөлбөрийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулаагүй байна

Орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1³⁷, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1³⁸, 39 дүгээр зүйлийн 39.7³⁹ дахь заалтыг биелүүлээгүй байна. Тухайлбал:

- 2014 онд Булган аймгийн Булган сумын 4-р байрны авто зогсоол барих 26.6 сая төгрөгийн ажлыг шууд гэрээ байгуулсан ба ХАА-г зохион байгуулахдаа төрийн бус байгууллагуудын төлөөлөл /иргэний төлөөлөл/-ийг хуралд оролцуулаагүй, Дорноговь аймгийн ХААГ нь тендерийн баримт бичгийн шаардлага хангаагүй, бүрдэл дутуу материалд үнэлгээ хийж, Эрин зууны суврага ХХК-ийг тендерт шалгаруулсан; Говь Алтай аймгийн орон нутгийн авто замын сангаас

³³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

³⁴ "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ."

³⁵ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

³⁶ "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана

³⁷ Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно...

³⁸ Худалдан авах ажиллагаанд ил тод өрсөлдөх, тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлана

³⁹ Техникийн болон санхүүгийн саналын оноог саналын урилгад тусгасан хувийн жинг харгалзан хооронд нь нэмж чанар үнийн үнэлгээний нийт оноог гаргана

хэрэгжүүлсэн 312.0 сая, 62.2 сая, 53.8 сая төгрөгийн зам барилгын ажлуудыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан, 33.5 сая төгрөг, 26.6 сая төгрөгийн зам барилгын ажлуудыг ЗД-ын 2014 оны А/228 тоот захирамжаар шууд гэрээгээр сонгон шалгаруулжээ.

Дээрхээс үзэхэд орон нутагт ТБОНӨХБАҮХАТХ-ийн хэрэгжилтэд тавих шат шатны хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний гэрээний зарим заалт биелээгүй, зорилтод үр дүндээ хүрээгүй байна

Сангийн хөрөнгөөр ажил үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуй нэгж гэрээний үүрэг, тендерийн бичиг баримт, техникийн нөхцлийг биелүүлж ажиллуулаагүйгээс төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал:

- Дорнод аймгийн орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр Авто агро ХХК-ийн гүйцэтгэсэн зам засварын ажил нь тендерийн нөхцөлд заасан өндөржилтийг хангаагүйгээс ус тогтдог, 2013-2014 онд Гашууны гол ХХК-ийн гүйцэтгэсэн автозамын хучилт элэгдсэнээс хайрга нь гарсан; Дорноговь аймгийн Сайншанд-Хамарын хийд чиглэлийн автозамд төлбөр хураах цэг барих ажлыг 15 хоногоор, Сайншанд сумын 1-р сургуулийн гадна авто зогсоол барих ажлыг 15 хоногоор, офицерийн чиглэлийн автозамд ус зайлуулах хоолой шинээр хийх ажлыг 87 хоногоор тус тус хэтрүүлсэн; Оргил таур ХХК нь төлбөр хураах цэг байгуулах ажил зураг төсвийн дагуу хийгдээгүй байна.



Дээрхээс үзэхэд орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5⁴⁰, 29 дүгээр зүйлийн 29.4⁴¹, ЗГТСТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1 дахь заалтыг зөрчиж төлөвлөдөг, сонгон шалгаруулалт явуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1⁴², 39 дүгээр зүйлийн 39.7⁴³, 47 дугаар зүйлийн 47.1⁴⁴-ийг тус тус зөрчдөг, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний нөхцлийн хэрэгжилтэд хяналт сул тавьж байгаа нь төсөл, арга хэмжээний үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

⁴⁰ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

⁴¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁴² Худалдан авах ажиллагаанд ил тод өрсөлдөх, тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлана

⁴³ Техникийн болон санхүүгийн саналын оноог саналын урилгад тусгасан хувийн жинг харгалзан хооронд нь нэмж чанар үнийн үнэлгээний нийт оноог гаргана

⁴⁴ Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.

3.2 Соёл, урлаг хөгжүүлэх сан

Сангийн хөрөнгөөр хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэхгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна

ССАЖС-ын 2014 оны А/38 дугаар тушаалаар СУХС-аас 26 чиглэлийн хөтөлбөр, арга хэмжээнд зориулж 5,700.0 сая төгрөг зарцуулахаар баталсан ба гүйцэтгэлээр 23 чиглэлийн төсөл, арга хэмжээнд 3,664.5 сая төгрөг зарцуулсан байна.

2014 оны батлагдсан төсвийг 1,377.4 сая төгрөгөөр хэмнэсэн боловч дээрх тушаалаар батлагдсан төлөвлөгөөний 4 чиглэлийн хөтөлбөр, арга хэмжээг 451.5 сая төгрөгөөр хэтрүүлэн санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

- Төрийн албан хаагчийн мэргэжил дээшлүүлэх, сургалт зохион байгуулахад батлагдсан төсвийг 55.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн; Орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлийг дэмжих ажлыг батлагдсан төсвөөс 169.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн; Соёлын болон урлагийн наадам зохион байгуулахад төлөвлөгөөнөөс 167.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн; ТББ-аас соёл, урлагийн ажил арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд 59.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

2014 онд СУХС-аас ЗГТСТХ-д заасан сангийн хөрөнгийг зарцуулах зориулалттай нийцэхгүй зарим арга хэмжээг санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.⁴⁵, 16 дугаар зүйлийн 16.5.⁴⁶, ЗГТСТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.3⁴⁷ дахь заалтуудыг хангаагүй байна. Тухайлбал:

- ССАЖС-ын 2014 оны А/339 тоот тушаалаар СУХС-ийн нягтлан бодогчийг Итали улсын Ром хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн нягтлан бодогчдын XIX чуулга уулзалт, сургалт”-д 11.3 сая төгрөгөөр оролцуулсан; ССАЖС-ын 2014 оны А/54 дүгээр музейн ажилтнуудыг БНХАУ-д ажлын туршлага судлуулах тушаалд хамруулан СУХС-ийн ажлын албаны 2 ажилтанг 3.8 сая төгрөгөөр оролцуулсан; ССАЖС-ын 2014 оны А/48 тоот “Сумын Соёлын төвүүдэд кино гаргалтын иж бүрэн тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах” тухай тушаалын дагуу 28.0 сая төгрөгийн 1 иж бүрдэл тоног төхөөрөмжийг боловсролын байгууллага болох Дорнод Их сургуульд олгосон;

Соёл, урлагийн салбарт хэрэгжүүлэх төслийг журмын дагуу шийдвэрлэдэггүй, сонгон шалгаруулалт хэрхэн явагдсан нь тодорхой бус байна

ССАЖС-ын 2013 оны А/143 дугаар тушаалаар баталсан “Соёл, урлагийн салбарт хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төслийг хүлээн авах шийдвэрлэх журам”-ын 1.1⁴⁸-д заасны дагуу шийдвэрлээгүй, сонгон шалгаруулалт хэрхэн явуулсан нь тодорхойгүй арга хэмжээнүүд байна. Тухайлбал:

Номын сангийн баяжилт, номын яармаг зохион байгуулах чиглэлээр хэрэгжүүлсэн 1 төсөлд 1.1 сая төгрөг; гадаад, дотоодод соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр хэрэгжүүлсэн 3 төсөлд 58.3 сая төгрөг, төрийн бус байгууллагаас соёл, урлагийн ажил арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн 4 төсөлд 17.6 сая төгрөг, 8 төсөлд нийт 77.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

2014 онд СУХС-ийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн 17 төсөл хөтөлбөрөөс дэмжигдээгүй 4 төсөл, хэлэлцэх боломжгүй 1 төсөл, нийт 5 төсөлд 82.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Тухайлбал:

⁴⁵ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁴⁶ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

⁴⁷ Энэ хуулийн 15.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна;

⁴⁸ тус журмыг соёл, урлагийн салбарт хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ, арга хэмжээ гүйцэтгэх төсөл, санал хүлээн авч, хэлэлцэн шийдвэр гаргахад мөрдөнө

- “Надад мөрөөдөл бий” баримтат кино бүтээхэд 7.0 сая төгрөг, Мерседес Бенз загварын шоууд “Ариунаа Сури” компани оролцох зардалд 17.1 сая төгрөг, Франц Улсад зохион байгуулагдсан олон улсын үндэсний бүжгийн фестивальд оролцох Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын жүжигчдийн хувцасыг шинэчлэх зардалд 54.8 сая төгрөг, “Прага квадриеннале”-ийн үзэсгэлэнгийн бэлтгэл ажилд оролцох зураач С.Ариунболдын замын зардалд 2.4 сая төгрөг, Их голомт сан ТББ-с эрхлэн хэвлүүлж буй “Их голомтын дуудлага” ном хэвлүүлэх зардалд 1.1 сая төгрөг тус тус олгосон;

Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй байна

ССАЖС-ын 2012 оны А/24 дүгээр тушаалаар батлагдсан СУХС-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.2⁴⁹-т заасны дагуу СУХС-аас 2014 онд санхүүжүүлсэн зарим уран бүтээлийн гэрээг байгуулахдаа тоглолтын орлогоос тодорхой хувийг санд эргэн төвлөрүүлэхээр тусгасан боловч дээрх заалтыг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- “Хас урлан” студи 2014 оны 36 дугаар гэрээний дагуу 4.0 сая төгрөг, Улсын драмын театр 2014 оны 49 дүгээр гэрээний дагуу нийт орлогын 8 хувийг, УДБЭТ 2014 оны 54 дүгээр гэрээний дагуу орлогын 8 хувийг, УДБЭЧ 2014 оны 79 дүгээр гэрээний дагуу орлогоос 2.2 сая төгрөгийг СУХС-ийн дансанд тус тус төвлөрүүлнэ гэж заасан боловч төвлөрүүлээгүй байна.

Аудитаар дээрх гэрээний заалтуудыг хангуулахаар нийт 6.9 сая төгрөгийн төлбөрийн акт тавьж барагдуулахаар шийдвэрлэв.

Мөн гэрээний хугацаа дууссан боловч гэрээнд заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж дуусаагүй төсөл, арга хэмжээнүүд байна. Тухайлбал:

- СУХС-ийн төлөвлөгөөгөөр түүхэн сэдэвт УСК бүтээхэд дэмжлэг үзүүлэхээр батлагдсан боловч сонгон шалгаруулалтын хувьд тодорхойгүй арт хэлбэрийн “Кондуктор” УСК-нд ССАЖС-ын 2014 оны А/243 тоот тушаалаар 53.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд тус кино хийгдээгүй;
- “Монголын шинжлэх ухааны сэтгүүлчдийн холбоо” ТББ-аас хэрэгжүүлж буй “Цаатны өв соёл” төсөлд ССАЖС-ын 2014 оны А/147 тоот тушаалаар 14.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд тус төсөл хэрэгжиж дуусаагүй.

ССАЖЯ-наас 2013 онд “Сумдын соёлын төвийг кино гаргалтын иж бүрэн тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах” ажлын дагуу 2014 онд нийт 13 суманд камер, 3 аймагт мини кино театрын тоног төхөөрөмжийг суурилуулсан боловч тус тоног төхөөрөмжийг ажиллуулах мэргэжлийн хүнийг бэлтгээгүй, интернетийн орчин бүрдээгүйгээс ашиглаагүй байна. Тухайлбал:

- Булган, Төв, Өмнөговь аймгийн соёлын төвүүдэд 2013, 2014 онуудад суурилуулсан кино гаргалтын тоног төхөөрөмжийг өнөөг хүртэл ашиглаагүй байна.

Мөн СУХС-аас Үндэсний номын сантай 2014 онд байгуулсан 63 тоот гэрээний үйлчлэх хугацаа, гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын жагсаалт тодорхой бус байгаа нь Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны №1 тушаалаар батлагдсан “төсөвт байгууллагын зарим ажил, үйлчилгээг гүйцэтгэх гэрээ”-ний шаардлагыг хангахгүй байна.

Дээрх зөрчлүүдээс үзэхэд сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ зорилтот үр дүндээ хүрээгүй байна.

⁴⁹ Сангийн хөрөнгөөр өөрийн оронд болон гадаад улсад зохион байгуулсан урлагийн тоглолт, соёл, урлагийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн үзэсгэлэнгийн орлого, хонжворт сугалаа, дуудлагын орлого

3.3 Дархлаажуулалтын сан

Вакцин био бэлдмэлийг худалдан авахад ТБОНӨХБАҮХАТХ-ийн зарим заалтыг мөрдөөгүй байна

Дархлаажуулалтын сангийн хөрөнгөөр 2014 онд нийт 4 удаагийн тендер сонгон шалгаруулалт явуулж шалгарсан 4 хуулийн этгээдтэй гэрээ байгуулснаас "Мөнхийн тун" ХХК-тай 2014 оны В2014/04 дугаартай гэрээг байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.2⁵⁰ дахь заалтыг, ЭМЯ-ны ТНБД-ын 2013 оны 373 тоот тушаалаар баталсан үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд "Эм" холбооны удирдах зөвлөлийн гишүүнийг оролцуулсан боловч уг гишүүн нь "АЗ" сертификатгүй байсан нь мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.6⁵¹ дахь заалтыг зөрчсөн байна.

Дархлаажуулалтанд нэг ампуль дахь хүн тунгийн хэмжээ өндөртэй вакцинууд нийлүүлэгдэж байгаа нь үр ашиггүй зардал гарах үндэс болж байна

НҮБ-ын Хүүхдийн сангаас сүрьеэгийн вакциныг 20 хүн тун, халдварт саагийн вакциныг 10 хүн тун, гепатит "В" вакциныг 10 хүн тун, сахуу татрангийн вакциныг 10 хүн тунгаар, улаанбурхан гахайн хавдар улаануудын вакциныг 5 хүн тунгаар нэг ампульд савласан байдлаар нийлүүлэх санал ирсний дагуу ЭМЯ гэрээ байгуулан худалдан авч байгаагаас найруулаад устгах вакцины хэмжээ өндөр гарч байна. Тухайлбал:

- Булган аймаг сүрьеэгийн вакцины 90.2 хувь, Говьсүмбэр аймаг 89.1 хувь, Дундговь аймаг 88.9 хувь, Архангай аймаг 87.4 хувийг тус тус найруулаад устгасан байна.

Аудитын явцад ЭМЯ, ХӨСҮТ-ийн мэргэжилтнүүдээс авсан асуулгаар "... НҮБ-ийн Хүүхдийн сан жилийн өмнө вакцины үнэ нэг ампуль дахь хүн тунгийн хэмжээ, үйлдвэрлэгчийн мэдээллийг ирүүлдэг ба эдгээр вакциныг гэрээ байгуулах үед гэрээнд заагдсанаас доош хүн тунгаар савлаагүй байсан гэж ойлгож болно" гэсэн хариултыг өгсөн бөгөөд энэ талаар НҮБ-ын Хүүхдийн сангаас 2014 онд хамгийн бага хүн тунтайгаар савлагдсан БЦЖ, сахуу татран, улаан бурхан гахайн хавдар улаанууд, тавт, "В" гепатит вакцинуудыг нийлүүлсэн гэсэн тайлбарыг ирүүлсэн болно.

Төв суурин газрын эмнэлгийн байгууллагууд вакцинжуулалтын ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулснаар устгах хүн тунгийн хэмжээг бууруулсан байна. Тухайлбал:

- Дархан-Уул: Аймгийн нийт өрхийн эмнэлэгүүд вакциныг долоо хоногийн 2, 4 дэх өдрүүдэд хийж байгаа нь 10 хүн тунтай САА, 5 хүн тунтай УГУ вакцины хаягдлыг багасгахад сайнаар нөлөөлсөн; Орхон: Үндэсний товлотт вакцинжуулалтыг нэгдсэн 3 цэгт хийснээр вакцины хорогдлыг багасгасан;

Үндэсний товлотт дархлаажуулалтаар 2014 онд НҮБ-ын хүүхдийн сангаас нийлүүлсэн нэг ампульдаа 5-20 хүн тунгаар савлагдсан 5 төрлийн вакцин дээр тооцоо хийж үзэхэд 920.3 сая төгрөгийн өртөгтэй 1,165,011 хүн тун вакцин ашигласнаас 588.7 сая төгрөгийн вакциныг тарьж, 331.6 сая төгрөгийн үнэтэй 458,390 хүн тун вакциныг найруулаад устгасны 294.7 сая төгрөгийн вакцин нь орон нутагт, 36.9 сая төгрөгийн вакцин нь нийслэлд хамаарч байгаа нь ЭМЯ-ны ТНБД Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалтыг хэрэгжүүлэх талаар санаачлагагүй ажилласан байна.

⁵⁰ Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.

⁵¹ Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

Дархлаажуулалт, урьдчилан сэргийлэх тарилгыг товлот хугацаанд нь бүрэн гүйцэтгэх, вакцин, био бэлдмэлийн хадгалалт, тээвэрлэлтийн горимыг чанд мөрдөх нөхцлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд сүүлийн 3 жилд хүйтэн хэлхээний төхөөрөмжийн 43 хувийг шинэчилсэнээр механик байдлаар гарах вакцины хорогдол дархлаажуулалтад ашигласан вакцины 0.26 хувь болгож бууруулжээ.

Тайлант онд 10,000 хүн амд ногдох урьдчилан сэргийлэх тарилгатай халдварт өвчний өвчлөл “А” вируст гепатит 1.1 болж өмнөх оноос 4.6 пунктаар, гахайн хавдар 1.5 болж 17.2 пунктаар, “В” вируст гепатит 2.0 болж 0.2 пунктаар буурсан бол сахуу, хөхүүл ханиад, татран, халдварт саа гараагүй нь дархлаажуулалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулсантай холбоотой байна.

3.4 Шинжлэх ухаан технологийн сан

Төвлөрсөн арга хэмжээний зардлыг эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардлаас санхүүжүүлжээ

Сангийн хөрөнгийг ЗГТСТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.3⁵² болон ШУТС-ийн дүрмийн 4.1⁵³ дэх заалтыг үндэслэн БСШУС-ын тушаалын дагуу зарцуулж байна.

ШУТС 2014 онд “эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, хөтөлбөр”-т 8,393.1 сая төгрөгийг зарцуулсны 465.1 сая төгрөгийг төвлөрсөн арга хэмжээнд зарцуулсан нь ЗГТСТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.4⁵⁴, ШУТС-ийн дүрмийн 6.1⁵⁵ дэх заалтыг тус тус хангаагүй байна. Тухайлбал:

- Шинжлэх ухааны ажилтны өдөрлөгт 59.6 сая төгрөг, 2014 онд үйл ажиллагаа явуулаагүй ШУТУЗ-ийн зардалд 8.9 сая төгрөг, ШУТСЗ-ийн үйл ажиллагааны зардалд 12.6 сая төгрөг, биеийн тамирын арга хэмжээний зардалд 10.0 сая төгрөгийг ЗГ-ийн 2014 оны 147 дугаар тогтоолыг зөрчиж, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах ажлын зардалд гэж, МТҮП-ийн урсгал зардалд 20.0 сая төгрөг, БШУЯ-ны ойн арга хэмжээний зардалд 1.9 сая төгрөг, цаг үеийн болзошгүй арга хэмжээний зардалд 12.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ШУТС-ийн 2014 оны урсгал зардлын гүйцэтгэлээс үзэхэд нийт дүнгээрээ 290.4 сая төгрөгийн хэмнэлттэй гарч, зардлын ангиллаар үзвэл гэрэл цахилгаанд 39.1 сая, гадаад томилолтод 6.6 сая, гадаад зочны зардалд 4.9 сая, бичиг хэргийн зардалд 1.3 сая, нэг удаагийн тэтгэмж 1.4 сая, урсгал зардалд 1.0 сая төгрөг буюу нийт 54.3 сая төгрөгийг хэтрүүлжээ. СЯ-ны 2014 оны 5 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу ангилал шилжүүлэн зохицуулсан боловч энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4⁵⁶, ЗГТСТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1⁵⁷ дэх заалтуудтай нийцээгүй байна.

⁵² Энэ хуулийн 6.4-т заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана...”

⁵³ Сангийн хөрөнгийг шинжлэх ухаан технологийн асуудал хариуцсан ЗГ-ын гишүүний шийдвэрээр зарцуулна

⁵⁴ Энэ хуулийн 20.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

20.4.1. шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа хийх;

20.4.2. Засгийн газрын /улсын/ захиалгатай шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх;

20.4.3. эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх.

20.4.4. инновацийн төсөл хэрэгжүүлэх, технологи, үйлдвэрлэлийн туршилт, зүгшрүүлэлтэд грант олгох.

⁵⁵ Сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно

⁵⁶ Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна.

⁵⁷ Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

ШУТ-ийн төслийг сонгон шалгаруулах журмыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна

БСШУЯ-ны Шинжлэх ухааны бодлого зохицуулалтын газар болон Инноваци өндөр технологийн газар төслийг захиалах, дэвшүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг 2014 оны 9 дүгээр сараас эхлэн ЗГ-ын 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-аар зохицуулж байна.

БШУЯ батлагдсан төсвийн хүрээнд 2014 онд хэрэгжүүлэх 799.0 сая төгрөгийн өртөгтэй 18 төслийг ШУТҮЗ-ийн зөвлөмжийг үндэслэлгүй БШУС-ын ШУТСЗ-ийн хуралдаанаар шалгаруулж гэрээ байгуулсан, ШУТ-ийн ижил сэдэвтэй төслийг 2 гүйцэтгэгчид хуваан олгосон, салбар яамдуудын захиалгатай төслийг шалгаруулахдаа ЗГ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “ШУТ-ийн төсөл, сэдэвт ажил хэрэгжүүлэх журам”-ын 36⁵⁸, 42⁵⁹ дахь заалтуудыг баримтлалгүй сонгон шалгаруулалт хийсэн байна.

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг тооцдоггүй, өр авлагаа барагдуулдаггүй, БСШУЯ зэхэц⁶⁰ ажлын зээлийн өрийг шийдвэрлэх тал дээр удаашралтай хандсан байна

ШУТ-ийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр захиалсан төрийн байгууллагууд болон ШУТСЗ нь 2014 онд ШУТС-тай байгуулсан 3,855.8 сая төгрөгийн өртөг бүхий 48 төслийн хэрэгжилт, үр дүнг гэрээний дагуу тус санд гаргаж өгөөгүй нь ЗГ-ийн 2010 оны “ШУТ-ийн төсөл, ажил хэрэгжүүлэх журам”-ийн 59 дүгээр зүйл, “Шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ”-ний Ерөнхий зүйлийн 1, хавсралт 2-т заасныг биелүүлээгүй байна.

2014 оны байдлаар 3.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий 48 төслүүдийг ЗГ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “ШУТ-ийн төсөл, сэдэвт ажил хэрэгжүүлэх журам”-ын 59.1⁶¹, 59.2⁶², 61⁶³ заалтуудыг зөрчиж санд бүртгээгүй нь журмын 58⁶⁴ дэх заалтын дагуу захиалагч яамдуудын ШУТ хариуцсан салбар зөвлөл болон ШУА-ын бага чуулганы холбогдох тушаал, шийдвэр гараагүй байгаатай холбоотой байна.

Иймд төсөл хэрэгжиж дуусахад захиалагч яам, ШУА, салбар зөвлөл нь ЗГ-ын 2010 оны 36 дугаар “ШУТ-ийн төсөл, ажил хэрэгжүүлэх журам”-ын 9 дүгээр зүйлийн дагуу хугацаандаа хуралдаж шийдвэрээ гаргаж өгч байх шаардлагатай байна.

Мөн БСШУС-ын 2010 оны 197 дугаар тушаалаар баталсан ШУТ-ийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээнд “Үүргээ биелүүлээгүй талын хүлээх хариуцлагыг талууд харилцан тохиролцох замаар энэхүү гэрээнд тодорхой тусгана” гэж заасны

⁵⁸ ШУТҮЗ-ийн зөвлөмжийг үндэслэн Шинжлэх ухаан технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шинээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг баталгаажуулна

⁵⁹ Сангийн хөрөнгөөс төсөл, сэдэвт ажилд зарцуулах х

өрөнгийн хувь хэмжээг ШУТҮЗ-ийн зөвлөмжийг үндэслэн Шинжлэх ухаан технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно

⁶⁰ БСШУС-ын 2008 оны 167 дугаар тушаалын 1.2-д “ШУТ-ийн зэхэц ажил гэж эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон, цаашид инкубаторт бойжуулан худалдах буюу шууд жижиг, дунд үйлдвэрлэл бий болгох боломжтой шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүний загвар, технологи, туршилтын тоног төхөөрөмж зэргийг хэлнэ

⁶¹ төслийн үр дүн, санхүүжилтийн талаар зохих журмын дагуу бичсэн төслийн тайланг салбар зөвлөлд хэлэлцүүлж, захиалагч, санхүүжүүлэгчид тогтоосон хугацаанд нь хүлээлгэн өгөх

⁶² төслийн хүрээнд бий болсон ШУ-ны шинэ мэдлэгийн талаар стандартын дагуу бичсэн эрдэм шинжилгээний ажлын тайланг итгэмжлэн хадгалагчид төсөл дууснаас хойш 3 сарын дотор хүргүүлэх

⁶³ Гүйцэтгэгч нь төсөл дууссанаас хойш 2 сарын дотор түүний үр дүнг захиалагчид актаар хүлээлгэн өгнө

⁶⁴ Захиалагч төслийн үр дүнгийн тайланг гүйцэтгэгчээс хүлээн авсанаас хойш 30 хоногт багтаан хянан магадлагаа хийлгэж үнэлэлт, дүгнэлт гаргуулна.

дагуу ШУТС хариуцлагын тодорхой заалтыг тусгаагүйн улмаас ажлын даалгаврын биелэлт хангалтгүй, хугацаандаа үр дүнгээ өгөхгүй байна.

ШУТ-ийн төсөл, ажил хэрэгжүүлэх журам болон ШУТС-ийн дүрмийн 3.1.д⁶⁵, 4.3.в⁶⁶ дэх заалтуудыг үндэслэн зэхэц ажлын зээлийг 2002 оноос эхэлж олгосон ба энэ хугацаанд 2.4 тэрбум төгрөгийн зээл олгосноос 2014 оны жилийн эцсийн байдлаар 19 төслийн 750.3 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй байгаа нь “Шинжлэх ухаан, технологийн зэхэц ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, санхүүжүүлэх, үр дүнг тооцох журам”-ийн 2.9 дэх заалт болон ШУТ-ийн зэхэц ажлыг эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэх гэрээний хугацааны заалтыг баримтлахгүй байна.

Дээрх журамд зэхэц зээлд хүү тооцох заалтгүй байхад “Шинжлэх ухаан, технологийн зэхэц ажлыг эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэх гэрээ”-нд зээлийн хүү тооцох заалт оруулсан нь уг тушаалыг зөрчиж байна.

БСШУЯ-ны сайдын 2008 оны 167 дугаар тушаалаар баталсан “Шинжлэх ухаан технологийн зэхэц ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, санхүүжүүлэх, үр дүнг тооцох” журмын 5.1⁶⁷, 5.2⁶⁸, 5.3⁶⁹ дахь заалтын дагуу ШУТС нь хугацаа хэтэрсэн зэхэц зээлийг төлүүлээгүй нь байна.

Сан нь ЗГ-ын 2014 оны “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ийн 7.1 дэх заалтын дагуу 2014 онд төслийн санхүүжилтээс 19.8 сая төгрөг хуримтлуулж БШУС-ын 2014 оны А/394 тоот тушаалаар “Хэрэгжиж буй төслүүдийн явц, үр дүнтэй танилцах, хяналт тавих, дүгнэлт гаргах” ажлын хэсгийн зардалд 20 сая төгрөгийн зардал батлуулж, 19.0 сая төгрөгийг зарцуулсан боловч ажлын тайлан байхгүй, үр дүн хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁷⁰, 16.5.5⁷¹-д заалттай нийцэхгүй байна.

⁶⁵ Эрдэм шинжилгээний байгууллагуудад эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжилт хийх, үр дүнг тооцох, олгосон хөрөнгийг эргүүлж төлүүлэх арга хэмжээ авах

⁶⁶ эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг нэвтрүүлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэх зардал

⁶⁷ Хугацаа хэтэрсэн санхүүжилт болон тодорхой шалтгаанаар санхүүжилт эргэн төлөгдөөгүй төлбөрийг сангийн удирдлага болон эргэн төлөгдөх хөрөнгийн асуудал хариуцсан ажилтан гэрээний дагуу гүйцэтгэгчид шаардлага тавьж төлүүлнэ

⁶⁸ Хэрэв гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд санхүүжилтийг төлөөгүй буюу хугацаа хэтэрүүлбэл энэ тухай гүйцэтгэгчид мэдэгдсэний дараа барьцаа хөрөнгийг сан өөрийн мэдэлд шилжүүлж авах эрхтэй

⁶⁹ Хугацаа хэтэрсэн санхүүжилтийн өр төлбөрийг барагдуулах талаар сангийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй гүйцэтгэгчийг гэрээнд заасны дагуу хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ

⁷⁰ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁷¹ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

БҮЛЭГ 4 САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

4.1 Авто замын сан

Орон нутгийн авто замын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих нэгж үүргээ хангалтгүй биелүүлсэн байна

Орон нутагт Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1⁷², 69.3⁷³, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1⁷⁴-д дагуу дотоод хяналт, шалгалтын тогтолцоо бүрдсэн боловч тухайн байгууллагуудын асуудал хариуцсан нэгж чиг үүргээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байна.

Тухайлбал, орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хийх аудитын хүрээнд аймаг, нийслэлийн аудитын газруудаас нийт 21 аймаг, нийслэлийн холбогдох байгууллагуудаас орон нутгийн авто замын сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтыг "4 аймаг хангалттай, 11 аймаг хангалтгүй, 6 аймаг огт хэрэгжүүлээгүй байна" гэж дүгнэсэн.

Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмын 19⁷⁵-д хяналтын үйл ажиллагааг тодорхойлсон боловч холбогдох хуулийн дагуу эрх шилжүүлснээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тавих захиалагчийн хяналт сулаас зарим хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээнүүд хугацаандаа, чанартай хэрэгжихгүй байгаа нь дотоод хяналт, шалгалт хийгдээгүйтэй холбоотой байна. Тухайлбал:

- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын замын тэмдэг, тэмдэглэгээг хийхдээ батлагдсан зураг төсвийг өөрчлөн хийж гүйцэтгэсэн ажлаа баримтаар баталгаажуулаагүй, Булган аймгийн тохижилт үйлчилгээний ангиар хийсэн 35.0 сая төгрөгийн Булган сумын 2.56 км замын авто замын засвар, арчлалтын явцад хяналт тавьж ажилласан ажлын тайлан мэдээ байхгүй, байгуулсан гэрээний 3.5-д "авто зам, замын байгууламжинд хийгдсэн засвар арчлалтын ажлын элементийн мэдээг 12 дугаар сарын 10-ны өдөр, 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус гаргаж захиалагчид албан тоотгоор ирүүлсэн байна" гэсэн гэрээний заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Мөн аймаг, орон нутгийн удирдлагууд гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах ажлыг дутуу хэрэгжүүлсэн, дотоод хяналт сул, хяналт тавих нэгж нь тодорхойгүйгээс өмч хөрөнгө эзэнгүйдэх, гүйцэтгэсэн ажлын чанар муудах, эвдрэх, гэмтэх, бүртгэлд тусгахгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь заалтыг тус тус зөрчиж байна. Тухайлбал:

⁷² Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

⁷³ Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.

⁷⁴ Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ.

⁷⁵ "Улсын болон орон нутгийн замын сангийн хөрөнгөөр барьж байгуулах, их засвар, өргөтгөл, засвар арчлалт хийх, зам, замын байгууламжийг барих гүйцэтгэгчийг шаардлагатай тохиолдолд Барилга, архитектурын газар сонгон шалгаруулалт явуулан сонгож, гэрээ байгуулан түүний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг Авто замын газар, аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцна"

- Нийслэлийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Хувьсгалчдын гудамжны 4.6 км замын 10 гэрэлтүүлгийн шон унаж гэмтсэн, Булган аймгийн орон нутгийн авто замын сангийн санхүүжүүлсэн 42.5 сая төгрөгийн хөрөнгө, үүнд 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн комиссын актаар ашиглалтанд оруулсан 27.6 сая төгрөгийн өртөгтэй авто пүү, “Тохижилт үйлчилгээний анги”-н зам засвар, арчлалтын ажил замын будаг сэргээхэд зарцуулсан 5.0 сая, замын тэмдэг, тэмдэглэгээний 14.8 сая төгрөгийн хөрөнгийг тус тус орлогод авч санхүүгийн тайланд тусгаагүй; Баянхонгор аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Түйн голын гүүрний гэрэлтүүлгийн тал нь алдагдсан, 1 нь эвдэрсэн, Баянхонгор аймгийн Өлзийт сумын Цагдаагийн постын 78.8 сая төгрөгийн цахилгааны шугамыг эзэмшигчид нь хүлээлгэж өгөөгүй, бүртгэлд аваагүй, замын цагдаагийн постыг шилжүүлэхэд гарсан 6.7 сая төгрөгийг бүртгэлд аваагүй байна.

Аудитын хугацаанд орон нутгийн авто замын сангаас зориулалт бусаар санхүүжүүлсэн, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах 7 арга хэмжээнд 25.1 сая төгрөгийн төлбөрийн акт, бүртгэлд аваагүй, хөрөнгө төвлөрүүлээгүй, хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй 27 арга хэмжээнд 1,764.6 сая төгрөгийн албан шаардлага өгсөн болно.

4.2 Соёл, урлаг хөгжүүлэх сан

Хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, зөрүүтэй үнэлсэн зөрчлүүд байна

СУХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг ЗГТСТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1⁷⁶, Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1⁷⁷, ССАЖС-ын 2013 А/143 дугаар тушаалаар баталсан “Соёл, урлагийн салбарт хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төслийг хүлээн авах шийдвэрлэх журам”-ын 4.3⁷⁸, СУХС-ийн дүрмийн 5.1.1⁷⁹-д тус тус тодорхойлсон боловч 2014 онд тус сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж байсан эсэх талаарх бичиг баримт, архивын баримтууд байхгүй байна.

Аудитын явцад сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтыг байгууллагууд данс бүртгэлд тусгаагүй, хөрөнгийг зөрүүтэй үнэлж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1⁸⁰ дэх заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Хэнтий аймгийн Биндэр сумын Соёлын төвд 2014 онд олгосон 8.0 сая төгрөгийн үнэтэй хяналтын камер, Төв аймгийн Батсүмбэр сумын соёлын төвд 2013 онд суурилуулсан 28.0 сая төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмжийг тус тус данс бүртгэлд тусгаагүй; Дундговь аймгийн болон Дорнод Аймгийн Музей үзмэрүүдийг ХХОАТ-ыг хассан дүнгээр, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын соёлын төв 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг суурилуулалт, тээврийн зардлыг хассан дүнгээр тус тус дутуу үнэлж бүртгэсэн; Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын соёлын төвд 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж суурилуулахаас 219.0 мянган төгрөгийн үнэ бүхий зүйл ирээгүй, Дорнод аймгийн ХДТ нэг бүр нь 275.0 мянган төгрөгийн үнэтэй эмэгтэй найрал дуучдын 11 хувцсыг гүйцэтгэгчээс хүлээн авсан гэж бүртгэл тайланд тусгасан ч 550.0 мянган төгрөгийн 2 хувцсыг дутаасан байна.

Сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтын тогтолцоо эрх зүйн хувьд бүрдсэн боловч ССАЖЯ, СУХС нь ЗГТСТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1, Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, ССАЖС-ын 2013 А/143 дугаар тушаалаар

⁷⁶ Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ

⁷⁷ Соёлын хяналтыг соёлын улсын хяналтын алба, улсын байцаагч, бүх шатны Засаг дарга хэрэгжүүлнэ

⁷⁸ Төслийн санхүүжилтийн зарцуулалт, тайлагналтад яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж хяналт тавина

⁷⁹ Сангийн менежер нь сангаас санхүүжүүлж буй уран бүтээл, соёл, урлагийн арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явцад хяналт тавьж, үр дүнг тооцох, эдгээртэй холбогдсон мэдээ, тайлан гаргуулж авах, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн ТЕЗ-тай зөвшилцөн санхүүжилтийг зогсоох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

⁸⁰ Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана

баталсан “Соёл, урлагийн салбарт хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төслийг хүлээн авах шийдвэрлэх журам”-ын 4.3, СУХС-ийн дүрмийн 5.1.1-д тодорхойлсон үүргээ биелүүлээгүй байна.

4.3 Дархлаажуулалтын сан

Зөвлөл сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3⁸¹ дахь заалтын хүрээнд Дархлаажуулалтын сангийн үйл ажиллагаанд 2013, 2014 онуудад ЭМЯ-ны Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний газраас хяналт тавьж ажиллаагүй бөгөөд 2015 онд ЭМСС-ын 11 дүгээр тушаалаар ажлын хэсэг томилогдож сангийн 2014 оны үйл ажиллагааг шалгаж дүгнэлт гаргасан байна.

Дархлаажуулалтын сангийн зөвлөлөөс сангийн үйл ажиллагаанд 2014 онд дотоод хяналт тавьсан талаар холбогдох бичиг баримт, архивын баримтууд ЭМЯ-нд байгаагүй нь ЗГТСТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1⁸², Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Дархлаажуулалтын сангийн зөвлөлийн ажиллах дүрэм”-ийн 7 дахь заалтын дагуу Зөвлөл санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Харин ХӨСҮТ-ын Дархлаажуулалтын алба Баян-Өлгий, Ховд, Өвөрхангай аймгуудын ЭМГ-тай хамтран дархлаажуулалтын үйл ажиллагаа, вакцины хадгалалт хамгаалалт, хүйтэн хэлхээний төхөөрөмжийн ашиглалтын байдалд, Архангай, Баян-Өлгий, Булган, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Хэнтий, Ховд аймгуудын ЭМГ дархлаажуулалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллан тодорхой зөрчлүүдийг илрүүлэн зааварчилгаа, зөвлөмж өгсөн ба дархлаажуулалтын асуудлаар иргэд аж ахуйн байгууллагуудад сурталчилгаа хийж ажилласан байна.

4.4 Шинжлэх ухаан, технологийн сан

Шинжлэх ухаан технологийн санд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй байна

ШУТС-ийн дүрмийн 3.1.а, 3.1.г, 3.1.д дэх заалтыг ШУТС-ийн удирдлага нь бүрэн биелүүлээгүйгээс төсөл, сэдэвт ажлыг захиалах, дэвшүүлэх, төсөл болон сэдэвт ажлын төсөвт өртгийг хуулийн хугацаанд зохих байгууллагад хүргүүлээгүй, төслийн үр дүнг гэрээгээр тогтоосон хугацаанд хүлээлгэж өгөөгүй, зэхэц ажлын авлагын үлдэгдлийг тогтсон хугацаанд барагдуулаагүй зөрчил гаргасан байна.

Түүнчлэн ШУТС нь дүрмийн 3.1-д “... шинжлэх ухаан, технологийн төслийг санхүүжүүлж, олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй зөвхөн төсөл хэрэгжүүлэгчийн гэрээнд заасан хугацаанд үр дүнгийн тайланг өгөөгүйг үндэслэн санхүүжилтийг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авч байгаа нь хангалтгүй байна.

Мөн ЗГ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “ШУТ-ийн төсөл, ажил хэрэгжүүлэх журам”-ын 53-д “Төсөл, сэдэвт ажлын арга зүйн түвшин, хэрэгжилтийн явц, хугацаа, үр дүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтэрсэн байдал, санхүүгийн үйл

⁸¹ Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.

⁸² Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ

ажиллагаанд эрх бүхий байгууллага хяналт тавина” гэж заасан боловч хяналт тавих эрх бүхий байгууллагууд нь тодорхой бус, хэрхэн хяналт тавих, хариуцлага тооцох, арга хэмжээ авах асуудал нь бүрхэг байгаагаас төсөл сонгон шалгаруулалт, гэрээ байгуулалт, санхүүжилт, ажлын даалгавар, явц, үр дүнд тавих хяналтын тогтолцоо хангалтгүй байна.

БШУС-ын 2014 оны А/394 дүгээр тушаалаар “Хэрэгжиж буй төслүүдийн явц, үр дүнтэй танилцах, хяналт тавих, дүгнэлт гаргах тухай” тушаал гаргаж, хэрэгжүүлсэн боловч, уг ажлын үр дүн тавьсан зорилгодоо бүрэн хүрээгүй байна.

4.5 Төсвийн ил тод байдлыг хангах, үйл ажиллагаагаа олон нийтэд мэдээлэх, Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж эхэлсэн байна

Аудитад хамрагдсан 4 сангаас ШУТС-ийн захирлын 2015 оны 20 тоот тушаалаар “Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл тавих журам”-ыг батлан 2015 оны 10 дугаар сарын байдлаар 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээнүүд болон 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны батлагдсан төсөв зэрэг мэдээллүүдийг байршуулж эхэлсэн байна.

Улсын авто замын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй Төлбөр хураах цэгүүд нь Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төвийн бүтцэд харьяалагдаж цалингаас бусад төрлийн 5 сая төгрөгөөс дээш гүйлгээ гараагүй, Дархлаажуулалтын санг Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоолоор татан буулгасан, СУХС-д 2015 онд хөрөнгө хуваарилж зарцуулаагүйгээс шилэн дансанд мэдээлэл байрлуулах боломжгүй болсон байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Автозамын сан

- "Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-д заасан байгууллага нь татан буугдсан, эрх үүрэг нь шилжсэн байхад уг журамд нэмэлт өөрчлөлт оруулаагүйгээс холбогдох заалтууд нь бусад хууль, журмуудтай нийцэхгүй байна.
- Улс болон орон нутгийн авто замын санд АТБӨЯХАТ, орон нутгийн авто зам ашигласны төлбөрөөс бусад хуулиар заагдсан эх үүсвэрийг бүрдүүлж чадахгүй байна.
- ОНАЗС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг төлөвлөх, сонгон шалгаруулахдаа Төсвийн тухай болон ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчдөг, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний хэрэгжилтэд хяналт сул тавьж байна.

Соёл, урлаг хөгжүүлэх сан

- СУХС-ийн Ажлын алба татан буугдаж сангийн эрх үүрэг нь БСШУЯ-д шилжсэн тул тус сангийн дүрэм, журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.
- Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бодитой төлөвлөдөггүй, нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулаагүй байна.
- Дотоод хяналт хангалтгүйгээс зарим гэрээнүүд зорилтот үр дүндээ хүрээгүй, хөрөнгө оруулалт үр дүнгүй хэрэгжих нөхцөл бүрдсэн, бэлтгэгдсэн данс бүртгэлд тусгаагүй, зөрүүтэй үнэлсэн байна.

Дархлаажуулалтын сан

- Зарим үндэсний товлотт вакцин ампульдаа 5-20 хүн тунтай савлагдсанаар нийлүүлэгдэж байгаагаас 2014 онд нийт вакцины 39.3 хувийг устгасан нь төсвийн үр ашигтай байдлыг хангахгүй байна.
- ЭМЯ, ЭМГ сайн дурын дархлаажуулалт болон урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай иргэн, байгууллага бүрэн хамруулж чадахгүй байна.
- Эрүүл мэндийн яамны Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний газраас 2014 онд дархлаажуулалтын сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна.

Шинжлэх ухаан, технологийн сан

- ШУТС-ийн захирал эрх мэдлээ хэтрүүлэн сангийн бүтэц, орон тоог баталсан байна.
- ШУТ-ын төсөл, сэдэв сонгон шалгаруулалт, төслийг батлах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулаагүй байна.
- ЗГ-ын 2014 оны 301 дүгээр тогтоолоор баталсан Шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх журамд заасны дагуу төслийн санхүүжилтээс хяналт шалгалтын ажилд авсан 1 хувийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулаагүй, төслийн санхүүжилтээс 465.1 сая төгрөгийг төвлөрсөн арга хэмжээний зардалд зориулалт бусаар зарцуулсан, 750.3 сая төгрөгийн зэхэц зээлийн авлагатай байгаа нь Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.

1

Холбогдох байгууллагын санал:



"Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн"-нд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын дүгнэлтэд тусгайлан өгөх саналгүй болно.





"Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн"-нд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 3 хуудас

Хүндэтгэсэн:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.БАТ-ЭРДЭНЭ



035046

ДАРХЛААЖУУЛАЛТЫН САНГИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН ЗӨРЧИЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН ЗҮГЭЭС ӨГӨХ ТОВЧ ТАЙЛБАР

УАГ-ын тайлбар
1.1-ийг үзнэ үү.

УАГ-ын тайлбар
1.2-ийг үзнэ үү.

УАГ-ын тайлбар
1.3-ийг үзнэ үү.

№	Нийцлийн аудитын явцад илэрсэн зөрчил	Тайлбар 1	Тайлбар 2
1	Бамнагтий, Бүлган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Завхан, Орхон, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хэнтий зэрэг 13 аймаг урьдчилан сэргийлэх тарилга, саян дурны дэрхлээжүүлэлтийн төлөвлөлтийг 2014 онд хийсэгүй.	Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил үйлчилгээ эрхэлж буй ажилтны хелатит В, боом, бэлчээд, шар чимрэг, урмах талын вакциныг тухайн ажилтныг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага нь, ийм төрлийн ажил хувиараа эрхэлгч нь сайн дураараа, төлбөрөө өөрөө төлөн хийлгэдэг. Иргэн, байгууллага хүсэлт гаргасан тохиолдолд сайн дурын вакциныг захиалгыг хийж төлөвлөлт хийдэг.	
2	УГУ, сүрьеэ, халдварт саа, хелатит В, сахуу татран зэрэг 5 төрлийн вакциныг амьсгундаа 5-20 хүн тунтайгаар нэхлүүлж байгаагаас 2014 онд 920,3 саа төгрөгийн өртөгтэй 1,161,011 хүн тун вакциныг дархлаажуулалтанд ашиглахаар найруулж 568.7 саа төгрөгийн өртөгтэй 706,621 хүн тун вакциныг тарьж 331.6 саа төгрөгийн өртөгтэй 468,380 хүн тун вакциныг устгасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дахь заалтыг зөрчсөн байна.	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй болно. Учир нь улсын хэмжээнд тухайн жилд шаардлагатай вакцины захиалгыг хийхдээ НҮБ Хүүхдийн санд шаардлагатай байгаа вакцины нэр төрөл, савлагаа, дуусах хугацаа, хүлээн авах хугацааг тусган санал тавьдаг. НҮБ Хүүхдийн сан дамжуулагчийн үүрэг гүйцэтгэн төвлөлийн вакцины захиалгыг шаардлагын дагуу мэдээллийг ирүүлсний үндсэн дээр захиалга хийгддэг. Тухайн вакцинуудын хувьд үйлдвэрлэгчээс боломжит хамгийн бага тунгаар савлагдсан вакцинууд болно.	0-15 насны хүүхдийн төвлөлийн дархлаажуулалтыг Засгийн газрын 2009 оны 185 дугаар тогтоолын хүрээнд, олон тунт задалсан вакциныг хэрэглэх журмыг Эрүүл мэндийн сайдын 2011 оны 122 дугаар тушаалд зааснаар УГУ, сүрьеэгийн эсрэг вакциныг задалснаас хойш 5 цагийн дотор хэрэглэн устгах, халдварт саа, хелатит В, сахуу татрангийн эсрэг вакциныг хадгалалтын явцад тодорхой шаардлага хангасан тохиолдолд задалснаас хойш 7 хоногийн дотор хэрэглэн үлдэгдлийг устгах заалттай. Олон хүн тунгаар савлагдсан, устгал бага гаргана гэж төвлөсөн хугацаанд нь зохих тунг аваагүйгээс тухайн хүүхдэд халдварт өвчний эсрэг дархлаа сул тогтох эрсдэлтэй. Жишээ нь: Хүүхдийг төрсний дараа сүрьеэ, саа, хелатит В-ын эсрэг вакциныг 24 цагийн дотор хийдэг. Тухайн орон нутагт төрөлт бага, хүүхэд цөөн байсан нь төвлөлийн дархлаажуулалтыг Засгийн газрын тогтоолоор батлагдсан хугацаанд нь зохих тунг хийх ёстой.
3	Дархлаажуулалтын сантай холбоотой үйл ажиллагааг 2001-2014 онуудад Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан "Дархлаажуулалтын сангийн ажиллах журм", "Дархлаажуулалтын сангийн зөвлөлийн дүрэм"-ээр зохицуулж ирсэн боловч энэхүү журмуудын холбогдох заалтууд хоорондоо болон бусад хууль тогтоомжтой зөрчилдсөнөөс Сан бие даан шийдвэр гаргах боломжгүй.	2015 онд Засгийн газрын тогтоолоор уг сан татан буугдсан учир сангийн үйл ажиллагаа зогссон. Дархлаажуулалтын тухай хуульд заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төв сангийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа.	Дархлаажуулалтын сангийн тогтвортой санхүүжилтийн үр дүнд вакцины хангалт эрс сайжирч вакцинтай халдварт өвчний гаралт эрс буурч, халдварт саа өвчнийг устгасан. Гэвч 2014 онд уг санг татан буулгасан. Сан татан буугдсанаар Монгол улсын засгийн газар ВДГА-тай хамтран хэрэглүүлж байгаа дархлаажуу-
	болсон байна. Тэмдэг тэмдэг хэлэмэл хуудасгүй бие даасан хуулийн этгээд биш тул албан ёсны шийдвэр гаргаж байгаагүй, хурлын гэмдэглэлээс өөр шийдвэр гэж үзэв баримт байхгүй.		лалтын үйл ажиллагаа зогсох шалтгаал бага насны хүүхдийн өвчлөлт өндөгдлийн гол шалтгаан болоод байгаа уушигны хатгалгаа өвчний эсрэг вакциныг нэвтрүүлэхэд дамжлаг үзүүлэхэд болон байгаа ВДГА-ын шаардлагыг хангаж чаддаггүйд хүрээд байгаа Түүнчлэн дархлаажуу-лалтын сангийн тогтвортой байдлыг өндөгдөж халдварт өвчин дэгдэлт хэлбэрээр гарахад тасалн зогсоох балин байдлыг хангахад хүндрэл учруулж байна. Тухайлбал энэ онд гарсан улаанбурхан өвчний дэгдэлтэд шаарддаг улаанбурханы эсрэг вакцины нөөц хангалтгүй байсны улмаас нийт 300.0 ам долларын санхүүжилтийг НҮБ-ын Хүүхдийн сангаас гаргуулсан болно.



Тайлбар хүргүүлэх тухай

"Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараахь тайлбарыг гаргаж байна.

Нэг. Шинжлэх ухаан технологийн сангийн талаар

ҮАГ-ын тайлбар
2.1.1-ийг үзнэ үү.

1. << Тайлангийн төслийн "Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах" 1-р бүлгийн 1.4-т "Төслийн сэдэвт ажлын өртөг, зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих асуудлыг зохицуулах журам"-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд батлаагүй байна, >> гэсэн тухайд.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 4-р сард А/127 дугаар тушаалаар "Шинжлэх ухаан, технологийн төслийн өртөг зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтанд санхүүгийн хяналт тавих журам"-ийн төсөл боловсруулах ажлын хэсгийг салбарын шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын төлөөлөл болох 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. 2015 оны 4 сарын 24-нд ажлын хэсгийн анхны хурлыг хийсэн бөгөөд журмын төслийг боловсруулан бэлэн болгоод байна. Журмын төслийг салбарын эрдэмтэн, судлаачдаар хэлэлцүүлсэн бөгөөд Яамны нэгжийн дарга нарын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулах шатандаа явж байна. Энэ журам батлагдсанаар ШУТ-ийн төслийн өртөг, зардлыг тодорхой нэгдсэн журмын хүрээнд бодитой төлөвлөх, боловсруулах, хянах механизм бүрдэх бөгөөд төслийн санхүүжилтын механизм, эрх зүйн орчин боловсронгуй болно. Ажлын хэсэг байгуулсан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/127 тоот тушаалыг хавсаргав.

ҮАГ-ын тайлбар
2.1.2-ийг үзнэ үү.

2. << Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж чадахгүй байна" 2-р бүлгийн 2.4-т "ШУТС-ийн санхүүжилтээр 2014 онд хэрэгжүүлэх төслүүдэд шаардагдах эх үүсвэрийг 9.1 тэрбум төгрөгөөр төлөвлөж төслийн ажлыг өртөг, зардлыг нарийвчлан тооцолгүй өмнөх оны гүйцэтгэлтэй ойролцоогоор батлуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан "ШУТ-ийн төсөл хэрэгжүүлэх санхүүжүүлэх журам"-ын 17, 38 дахь заалтыг зөрчсөн байна, >> гэсэн тухайд.

09 226

Төсвийн тухай хуулийн хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа салбарын жил бүрийн төсвийн төслийг боловсруулж Сангийн сайдад хүргүүлдэг боловч Засгийн газар болон Улсын Их Хурлаар тухайн оны төсөв хэлцэгдэн батлах үед хасагддаг. Тухайлбал 2014 оны төсвийн төсөлд эрдэм шинжилгээ судалгаа боловсруулалтын ажилд зориулж 33.4 тэрбум төгрөг төсөвлөж саналаа хүргүүлсэн нь өнгөрсөн оноос 23,8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 8.1.3 дахь хэсэгт зааснаар Шинжлэх ухаан, технологийг 2007-2021 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Үндэсний инновацийн тогтолцоог 2008-2015 онд хөгжүүлэх төлөвлөгөө, Монгол улсын шинжлэх ухаан технологийг 2010-2014 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтыг үндэслэн 2014 оны төсөвт зайлшгүй шаардлагатай тул Эрдэм шинжилгээний зардал өсч боловсруулагдсан.

Шинжлэх ухааны салбарын төсвийг нэмснээр үр дүнтэй хэрэгжих дээрх төслүүдийг санхүүжүүлэх боломжтой болно. Доорх хүснэгтээр 2014 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан нийт төслүүдийн жагсаалтыг харуулъя.

Хүснэгт 1 Шинжлэх ухаан, технологийн судалгааны ажлын 2014 оны эрдэм шинжилгээний зардлын задаргаа

Д/д	Судалгаа боловсруулалтын ажлын төрөл	2014 онд үргэлжлэх		2014 онд шинээр эхлэх		2014 онд нийт хэрэгжих		Нэг СБА-д ногдох зардал
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	ШУТТөсөл	56	2,331,452.1	135	7,324,885.0	191	9,656,337.1	50,556.7
2	Сэдэвт ажил	68	1,471,600.0	123	10,381,880.6	191	11,853,480.6	62,060.1
3	Инновацийн төсөл	27	1,355,870.6	51	3,670,000.0	78	4,925,870.6	63,152.2
4	Хамтарсан төсөл	58	410,600.0	50	650,000.0	108	1,060,600.0	9,820.4
5	Залуу судлаачдын грант	0	-	12	48,000.0	12	48,000.0	4,000.0
6	Залуу докторын грант	10	50,000.0	15	75,000.0	25	125,000.0	5,000.0
7	ШУА-ийн грант	0	-	15	64,000.0	15	64,000.0	4,266.7

8	Цөм технологи	8	1,108,170.0	14	2,744,000.0	22	3,853,170.0	75,144.1
9	Зэвсэг ажил	0	-	10	795,000.0	10	795,000.0	79,500.0
10	Төвлөрсөн арга хэмжээ	0	-	0	1,023,000.0	0	1,023,000.0	
	Нийт дүн	227	6,728,692.7	425	26,675,765.6	652	33,404,458.3	1,223.8

Сүүлийн 4 жилийн хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөгч захирагчийн төсвийн төсөлд эрдэм шинжилгээ судалгаа боловсруулалтын ажлын зардлыг 20 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлага байгаа саналыг тусгадаг боловч эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүсч байгаатай холбогдуулан төсвийг өмнөх оноос нэмэгдүүлэх боломжгүй гэсэн үндэслэлээр Сангийн яаманд хасагддаг болно.

3. << ШУТ-ийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэрийг зөвхөн улсын төсвөөс бүрдүүлж, бусад үүсвэрээс бүрдүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулж байгаа нь ШУТ-ийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. >> гэсэн тухайд.

Дээрхи дүгнэлт нь 2014 онд эрдэм шинжилгээний хүрээлэн төвүүдийн Төсвийн нэмэлт орлогын дансанд 5,159.3 сая төгрөгийг төвлөрүүлж, төсвийн шууд захирагчийн хүрээнд Сангийн яамнаас эрх нээлгэн зарцуулсан гэсэн тайлбартай зөрчилдөж байна.

Сан болон түүний харъяа хүрээлэн төвүүд нь "Шинжлэх ухаан, технологийн тухай" хуулийн 14.1 дэх заалтын дагуу үйл ажиллагааны санхүүжилтын таван эх үүсвэрээр хөрөнгө бүрдүүлэн ажиллаж байна.

1. Улсын төсвөөр: 2013 онд нийт 25,596.00 сая төгрөг, 2014 онд 26,083.20 төгрөгний нийт санхүүжилт авсан.

2. Орон нутгийн төсвөөр: Информатикийн хүрээлэн нийслэлийн удирдлагатай хамтаран Улаанбаатарын гэрэлтүүлэгийн систем, хяналт удирдлага хийх төсөл, Гоезкологийн хүрээлэн Төвийн аймгийн байгаль хамгаалах сан хамтран "Төв аймгийн Дэлгэрхаан, Баянхангай, Лүн, Угтаалцайдам, Эрдэнэсант, сумдын нутгийн цөлжилтийн одоогийн төлөв байдал цөөшид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах", Ургамал хамгааллын хүрээлэн "Нийслэлийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн кортон шавьж усгах, ариутгах" гэрээт ажлын гүйцэтгэх ажлаар орон нутгийн төсвөөс 256.53 сая төгрөгний санхүүжилт авсан.

3. гаднаад улс, олон улсын байгууллагаас олгосон хөрөнгө: Дэлхийн банк, НҮБ зэрэг олон улсын байгууллагаас төсөл хэрэгжүүлэх болон санхүүжилт хэлбэрээр 1,424.68 сая төгрөгийн төсөв бүрдүүлсэн.

ҮАГ-ын тайлбар
2.1.3-ийг үзнэ үү.

4. гадаад улсын болон Монгол Улсын иргэн, байгууллага, хуулийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламж: 2014 онд Гадаад, дотоодын аж ахуйн нэгжээс хандив тусламжаар 2,193.95 сая төгрөгний хөрөнгө авсан байна.

5. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр: Төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх, шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн борлуулах зэргээр ААНэгж, хувь хүнээс нийт 1,572.18 сая төгрөгний орлого нэмэлтээр олсон.

Шинжлэх Ухаан Технологийн сан нь салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилгоор олон үйл ажиллагаа хэрэгжүүлж ажиллаж байна. 2015 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ы ШУТМТ, ТДТ, Өвөрмонголын ХААИС, Хөдөө аж ахуй, мал аж ахуйн академи, Өвөрмонголын их сургууль зэрэг байгууллагын төлөөлөгчидтэй уулзалт хийж Хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэд хамтарч хэрэгжүүлэх 20 сая долларын дүн бүхий төслийн саналаа танилцуулж, үүний үр дүнд ойрын хугацаанд хамтарсан төсөл боловсруулж, засгийн газарт өргөн барихаар тохиролцож санамж бичигт гарын үсэг зурсан. Мөн ӨМӨЗО-ы Бүс нутгийн дэд тэргүүлэгч Бай Шон Чун болон албаны бусад төлөөлөгчидтэй уулзалт хийж "Монгол улсад анхны ШУП байгуулах талаар хамтран ажиллах тухай санамж бичиг" болон ШУТ-ийн Хамтарсан хорооны хурлын тэмдэглэлийн хүрээнд Монгол улсад Монгол-Хятадын хамтарсан инкубатор төвийн байрыг шинээр барих талаар харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж 12 сая долларын хөрөнгө оруулалт авахаар тохиролцсон байна.

**ҮАГ-ын тайлбар
2.1.4-ийг үзнэ үү.**

4. << Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байна" 3-р бүлгийн 3.4-т "ШУТС-ийн удирдлага 2014 онд эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, хөтөлбөрт 8,8 тэрбум төгрөг төлөвлөгдөж, 8.4 тэрбум төгрөгийг зарцуулсанаас 465.1 сая төгрөгийг төвлөрсөн арга хэмжээний зардалд зориулалт бусаар зарцуулсан нь ЗГТСТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.4, ШУТС-ийн дүрмийн 6.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна. >> гэсэн тухайд.

"Засгийн газрын тусгай сангийн тухай" хуулийн 5.1-р заалтын "Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийн орлогыг Засгийн газрын тусгай сан /цаашид "Тусгай сан" гэх/ гэнэ" дагуу тус сан нь шинжлэх ухаан технологийн үйл ажиллагааг хариуцсан тусгай сан юм.

"Засгийн газрын тусгай сангийн тухай" хуулийн 20.4.3 -т заасан Эрдэм Шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, "Шинжлэх Ухаан Технологийн тухай" хуулийн 72-р зүйл, 93-р зүйлд заасны дагуу ШУҮЗөвлөл, ШУСалбар зөвлөл байгуулах, 2010 оны 2-р сарын 10-ны өдрийн 36-р тогтоолын дагуу төслүүдийг сонгон шалгаруулалт хийх мэргэжлийн олон чиглэлийн шинжээчдийн баг бүрдүүлэх, Улсын Их хурлын 1998 оны 05-р сарын 14-ны өдрийн дугаар 55 тогтоол, Засгийн Газрын 2010 оны 7-р сарын 07-ны өдрийн дугаар 174 тогтоол, 2008 оны 7-р сарын 18-ны Сайдын 379-р тушаалаар батлагдсан "ШУТСангийн дүрэм"-ийн 3-р бүлэг ё хэсэгт заасны дагуу шинжлэх ухааны салбарыг дэмжих, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол улсын шинжлэх ухаан хөгжих үйл явцад том хувь нэмэр оруулж байгаа чуулга уулзалт зохион байгуулах, "Шинжлэх ухаан технологийн тухай" хуулийн 16.4

заалт, 2007 оны 6-р сарын 20-ны өдрийн Засгийн газрын 147-р тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 7-р сарын 01-ны өдрийн 324-р тушаал, 2010 оны 11-р сарын 01-ний өдрийн 479-р тушаалыг үндэслэн шинжлэх ухааны оны шилдэг бүтээл шалгаруулж шагнах, залуу судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, грант олгох зэрэг үйл ажиллагааны төсөв Шинжлэх ухаан технологийн санд батлагдан зарцуулагддаг.

Төвлөрсөн үйл ажиллагааны зардлыг Шинжлэх ухаан технологийн сан нь "Засгийн газрын тусгай сангийн тухай" хуулийн 26.36-р зүйл заалтын дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар зарцуулдаг болно.

**ҮАГ-ын тайлбар
2.1.5-ийг үзнэ үү.**

5. << ШУТС-ийн дүрмийн 3.1.д- д заасны дагуу 4.3, дэх заалт, 4.3.в дэх заалт гэсэн заалтыг үндэслэн зэхэц ажлын зээлийг 2002 оноос олгож эхэлсэн ба энэ хугацаанд олгогдсон нийт 2,4 тэрбум төгрөгийн зээл олгосноос 2014 оны жилийн эцсийн байдлаар 19 төслийн 750.3 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй байгаа нь "ШУТ-ийн зэхэц ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, санхүүжүүлэх, үр дүнг тооцох журам"-н 2.9 дэх заалт болон ШУТ-н зэхэц ажлыг эргэж төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлэх гэрээний хугацааны заалтыг баримтлахгүй байна. Дээрх журамд зэхэц зээлд хүү тооцох заалтгүй "ШУТ-ийн зэхэц ажлыг эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэх гэрээ"-нд зээлийн хүү тооцох заалт оруулсан нь уг тушаалыг зөрчиж байна. >> гэсэн тухайд.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 4 дүгээр сарын 09-ны өдрийн 167 дугаар тушаалын хавсралт "ШУТ-ийн зэхэц ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, санхүүжүүлэх, үр дүнг тооцох журам", ШУТС-ийн дүрмийн 3.1.д- д заасны дагуу 4.3, дэх заалт, 4.3.в дэх заалт гэсэн заалтыг үндэслэн зэхэц ажлын зээлийг олгож эхэлсэн ба энэ хугацаанд олгогдсон нийт 2.4 тэрбум төгрөгийн 100 зэхэц зээлээс 750.3 сая төгрөгийн 19 зэхэц зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс хугацаа хэтэрсэн санхүүжилт болон тодорхой шалтгаанаар санхүүгийн эргэн төлөгдөөгүй төлбөрийг Сангийн удирдлага болон эргэн төлөгдөх хөрөнгийн асуудал хариуцсан ажилтан гэрээний дагуу гүйцэтгэгчид шаардлага тавьж төлүүлнэ хэмээн заасан боловч уг гэрээг байгуулах баталгаажилтыг шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гаргасан учир хохирогч нь тухайн байгууллага болж байна. Иймд ШУТСан нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамд удаа дараа шүүхэд нэхэмжлэл гаргах талаар санал хүргүүлсэн байна. Зэхэц ажлыг хэрэгжүүлэх гэрээний дагуу хугацаа дууссан зэхэц зээлийн "Үл хөдлөх хөрөнгийн барьцаа"-г ШУТСангийн мэдэлд шилжүүлэх тухай хууль хяналтын байгууллагын шийдвэр гараагүй тул барьцаа хөрөнгийг шилжүүлэн авах боломжгүй болсон байна.

**ҮАГ-ын тайлбар
2.1.6-ийг үзнэ үү.**

6. Сан нь ЗГ-ын 2014 оны "ШУТ-ийн төсөл хэрэгжүүлэх журам"-ын 7.1 дэх заалтын дагуу 2014 онд төслийн санхүүжилтээс 19.8 сая төгрөг хуримтлуулж Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/394 тоот тушаалаар "Хэрэгжиж буй төслүүдийн явцад хяналт тавих үнэлэлт дүгнэлт өгөх" ажлын хэсгийн зардалд 20.0 сая төгрөгийг батлуулж, 19.0 сая төгрөгийг зарцуулсан боловч ажлын тайлан байхгүй, үр дүн хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1, 6.5.5-д заасныг зөрчсөн байна.

Дээрх ажлын хүрээнд хийсэн ажлын үр дүнд гүйцэтгэгч байгууллага болон төслийн удирдагч нарын зүгээс хэрэгжиж дууссан ажлын тайлангаа хүлээлгэн өгөх, явцын тайлан болон мониторингийн картыг бөглөж ирүүлэх ажлуудад нилээд ахиц гарсан. Төслийн захиалагч яамд болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны намны холбогдох газруудад төслүүдийн мониторингийн дүгнэлт гаргах, дууссан ажлын үр дүнг үнэлж хүлээж авах, хэрэгжиж буй ажлуудын хэрэгжилтийн байдалтай танилцаж үнэлгээ өгөх талаар албан бичиг хүргүүлж ажиллав. Түүнчлэн ШУТ Сангийн зүгээс мониторинг хийсэн төслүүдийн талаарх саналыг мөн хүргүүлсэн.

1. Эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль болон хувийн хэвшлийн 10 гаруй байгууллагын нийт 30 гаруй төслийн хэрэгжилтийн явцтай танилцсан байна. Үүнд: суурь судалгааны төсөл – 10, ШУТ-ийн төсөл – 12, инноваци – 8, цөм технологи – 1

2. Дээрх төслүүдийн хэрэгжилтийн явцаас үзэхэд нийт танилцсан төслүүдийн 83% нь “хангалттай” гэсэн үнэлгээ авсан байна.

3. Хэрэгжиж буй төслүүдийн явцын тайлан, мониторингийн карт бөглөж ирүүлэх ажлын явц 90 хувьтай байна.

4. Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээний 2.1-т заасан заалтуудын дагуу захиалагч “төслийн гүйцэтгэл, санхүүжилтийн байдалд бэйнгын хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх”, “төслийн хэрэгжилтийн явцыг үндэслэн санхүүжилт олгох /зогсоох/ тухай албан ёсны саналыг хагас жил тутам санхүүжүүлэгчид ирүүлж байх” зэрэг үүргийг хүлээнэ.

Дээрх тайлбаруудтай танилцан аудитын дүгнэлтэд анхаарч ажиллахыг хүсье. Мөн дүгнэлтийн зөвлөмж хэсэгт байгаа Шинжлэх ухаан технологийн сангийн зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох гэсэн хэсгийг хасах, дүгнэлт хэсэгт сангийн гаргасан алдаа дутагдлыг яаж засаж залруулах талаар зөвлөмж, арга зүй боловсруулж ирүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хоёр. Соёл урлагийн сан

Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2014 оны үйл ажиллагаа, санхүүгийн гүйцэтгэлд нийцлийн аудит хийж, зөвлөмжийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд ирүүрсэнтэй танилцлаа.

Соёл, урлаг хөгжүүлэх сантай ажил, арга хэмжээ зохион байгуулах гэрээ байгуулж зохих орлогыг төвлөрүүлэх үүрэг хүлээсэн мэргэжлийн урлагийн байгууллагад нийцлийн аудитын актыг танилцуулж гэрээний үүргийн биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж байна.

Нийцлийн аудитын зөвлөмжид Соёл, урлаг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбогдон бичигдсэн зарим зүйлд доорхи тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

Зөвлөмжийн 1.2-т дурьдсан “2015 оны төсвийн хөрөнгийг сангийн дансанд байршуулаагүй Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн санд байршуулсан” гэх зүйлд.

ҮАГ-ын тайлбар 2.2.1-ийг үзнэ үү.

**ҮАГ-ын тайлбар
2.2.2-ийг үзнэ үү.**

Сангийн яамнаас 2015 оны төсвийн хуваарилалтыг хийхдээ Соёл, урлаг хөгжүүлэх сангийн төрийн санд хөрөнгийн хуваарилалт хийгээгүй ба Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төрийн сангийн дансанд шилжүүлсэн болно.

Зөвлөмжийн 2.2-т дурьдсан...зарим төсөл, хөтөлбөрийн төсвийг хэтрүүлсэн талаархи тайлбарыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас ирүүлгээгүй байна. гэх зүйлд.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь дээрхи сантай холбоотой тайлбарыг Соёл, урлаг хөгжүүлэх сангийн захиралаар ажиллаж байсан Н.Батмөнхөөр тайлбар гаргуулж arunzaya@audit.gov.mn цахим хаягаар захидал илгээсэн.

**ҮАГ-ын тайлбар
2.2.3-ийг үзнэ үү**

Мөн хэсэгт сангийн ажилтан зарим ажилтанг гадаадад ажил, мэргэжлийн туршлага судлуулах, сургалтад хамруулсанг төсвийг буруу зүйлд зарцуулсан мэт ойлголт төрүүлэхээр болжээ. Соёл, урлаг хөгжүүлэх сан нь соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний байгууллага ба ажилтан нь төрийн албан хаагчийн хувьд тус салбарын ажилтан тул мэргэжил дээшлүүлэх сургалт арга хэмжээнд хамрагдсан болно. Сангийн хөрөнгөөр Дорнод аймагт боловсролын байгууллага, Төв аймагт оюутаны сургалтын зардал зарцуулсан гэх ташаа дүгнэлтийг орсон байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Сангийн дүрэмд сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг зөвхөн Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргахаар заасан тул сангийн дэргэдэх зөвлөлийн хурал түүний шийдвэр нь Сайдад зөвлөмж, санал хүргүүлэх үүрэгтэй болно.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь нийцлийн аудитаас Соёл, урлаг хөгжүүлэх сангийн талаар өгсөн зөвлөмжийг цаашид өөрийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллах болно.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



ШБУЛГА-ЭРДЭНЭ

ҮАГ-ын тайлбар:

Нэг. ЭМСЯ-наас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

ҮАГ-ын тайлбар 1.1	Хүлээн авах боломжгүй.
ҮАГ-ын тайлбар 1.2	Хүлээн авч өөрчлөлтийг хийв.
ҮАГ-ын тайлбар 1.3	Хүлээн авах боломжгүй.

Хоёр. БСШУЯ-наас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

ҮАГ-ын тайлбар 2.1.1	Хүлээн авах боломжгүй.
ҮАГ-ын тайлбар 2.1.2	Хүлээн авч өөрчлөлтийг хийв.
ҮАГ-ын тайлбар 2.1.3	Хүлээн авч өөрчлөлтийг хийв.
ҮАГ-ын тайлбар 2.1.4	Хүлээн авах боломжгүй.
ҮАГ-ын тайлбар 2.1.5	Хүлээн авах боломжгүй.
ҮАГ-ын тайлбар 2.1.6	Хүлээн авах боломжгүй.
ҮАГ-ын тайлбар 2.2.1	Хүлээн авах боломжгүй.
ҮАГ-ын тайлбар 2.2.2	Хүлээн авч өөрчлөлтийг хийв.
ҮАГ-ын тайлбар 2.2.3	Хүлээн авч өөрчлөлтийг хийв.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна.

Зам тээврийн сайдад:

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Авто замын тухай хуулиар тодорхойлсон Улсын авто замын сан, орон нутгийн авто замын сангийн үзэл баримтлал, эрх зүйн орчныг шинэчлэх асуудлыг судалж хууль, журмын дагуу шийдвэрлэх,
2. Орон нутгийн авто замын сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах,

Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдад:

1. Сангуудын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн батлах,
2. Соёл урлаг хөгжүүлэх сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу төрийн сангийн тусгай дансанд байршуулах,
3. Сангуудын төсвийн санхүүжилтээс бусад эх үүсвэрээс олох орлогыг нэмэгдүүлэх ажлыг хууль, журмын хүрээнд зохион байгуулах,
4. Сангуудын хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах,
5. Шинжлэх ухаан технологийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан албан тушаалтанд хариуцлага тооцох,
6. Шинжлэх ухаан технологийн сангийн үйл ажиллагааг хууль, Шинжлэх ухаан технологийн сангийн төсөл хэрэгжүүлэх журамд нийцүүлэн зохион байгуулах.

Эрүүл мэндийн сайдад:

1. Дархлаажуулалтын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах,
2. Олон улсын байгууллагуудаас нийлүүлж буй вакцины үр ашгийн тооцоог нарийвчлан хийж 1 ампульд нийлүүлэх хүн тунгийн хэмжээг бууруулах боломжийг судалж, шийдвэрлэх,

ШУТС-ийн 2014 онд дууссан тайлангаа өгөөгүй төслүүдийн жагсаалт															Хавсралт № 1
№	Гэрээний дугаар	Сайд тушаалын огтло	Сайд тушаалын огтло	Төслийн нэр	Эхэлсэн он	Дууссан он	Гүйцэтгэгч байгууллага	Эрдэм шинжилгээ	Удирдагчийн нэр	2011	2012	2013	2014	Нийт олгосон санхүүжилт	Тайлбар
1	SSA_003/12	558	12/30/2011	Диметиллийн эфирийн шууд синтезийн катализаторын судалгаа	2012	2014	МУИС	56,100.0	Б.Энхсаруул		13,700.0	20,000.0	12,000.0	45,700.0	ШУА-ийн бага чуулган
2	SSA_004/12	558	12/30/2011	Хэсийн баяжуулалт, эх орны эрдэс түүхий эрдэс нунтаг будагч бодис нийлмэлт гаргах судалгаа	2012	2014	МУИС	54,000.0	Д.Эрдэнэчимэг		18,000.0	8,000.0	18,000.0	44,000.0	ШУА-ийн бага чуулган
3	SSA_005/12	558	12/30/2011	Агаар мандалд явагдах оптик үзэгдлийн судалгаа	2012	2014	МУИС	45,000.0	Ц.Баатарчулуун		6,000.0	15,000.0	15,000.0	36,000.0	ШУА-ийн бага чуулган
4	SS_12/014	558	12/30/2011	Монгол Алтайн нурууны эмийн ургамлын судалгаа	2012	2014	ЭЗСТ	51,000.0	У.Бекет		36,169.1	-	-	36,169.1	ШУА-ийн бага чуулган
5	SS_12/018	558	12/30/2011	Дагуурын хээрийн биологийн олон янз байдлын харьцуулсан судалгаа	2012	2014	МУИС	52,000.0	Р.Самсаяа		14,000.0	8,000.0	19,000.0	39,000.0	ШУА-ийн бага чуулган
6	SS_12/022	558	12/30/2011	Хараа голын ай савийн усны эргэлт, усны хэрэглээний судалгаа	2012	2014	ГЗХ	129,800.0	Д.Баттогтох		63,266.3	8,000.0	17,000.0	88,266.3	ШУА-ийн бага чуулган
7	SSA_001/12	558	12/30/2011	Монгол орны ба антарктидын уур амьсгалын өөрчлөлтийн харьцуулсан судалгаа	2012	2014	ШУТИС	45,000.0	Л.Дүгэржав		15,000.0	15,000.0	15,000.0	45,000.0	ШУА-ийн бага чуулган
8	SS_12/029	558	12/30/2011	Нүүдлийн иргэний дэх хотжилт: Түүхэн туршлага, хөгжлийн бэрхшээл, гарц	2012	2014	ОУХ	50,000.0	Б.Энхтүвшин		31,297.4	3,000.0	8,000.0	42,297.4	ШУА-ийн бага чуулган
9	SS_12/031	558	12/30/2011	Хэлц нэгжийн судалгаа, (Угсаа-сэтгэл хэл шинжлэл, хэлний соёл судлалын аспект)	2012	2014	МУИС	39,900.0	Ж.Баансан		13,300.0	8,000.0	13,300.0	34,600.0	ШУА-ийн бага чуулган
10		163	4/10/2012	Экосистемийн үнэ цэнийг тодорхойлох, экосистемийн үйлчилгээний төлбөр (PES)-ийг тооцох аргачлал	2012	2014	GeoX	50,000.0	Ж.Цогтбаатар		20,000.0	15,000.0	15,000.0	50,000.0	БОНХА хүлээгдэж байгаа
11		163	4/10/2012	Хүлд өргийн загас үржүүллийн судалгаа, туршилтын ажил	2012	2014	GeoX	59,000.0	Г.Мэндсайхан		29,000.0	10,414.0	18,000.0	57,414.0	БОНХА хүлээгдэж байгаа
12	COR_01/2012	234	5/15/2012	Хайрст үлд өвчний үед ажилладаг сэргээгч болон Т.Эсүүдийн хоорондын холбоо хамаарлыг судлах	2012	2014	ЭМШУ ИС	10,380.0	Г.Батбаатар		-	-	10,380.0	10,380.0	хуулийн хугацаа дууссан
13	COR_02/201	234	5/15/2012	Цөлжилттэй тэмцэх агро-ойн зохиомилт хувилбарыг боловсруулах	2012	2014	МУИС	10,380.0	Н.Батхүү		-	-	10,380.0	10,380.0	хуулийн хугацаа дууссан
14	RUSS_15/20	248	5/18/2012	Дагачалалын үеийн Монгол Оросын хилийн бүс нутаг дахь шашны уламжлал ба шинэ хандлага	2012	2014	ТүүХ	6,000.0	Ц.Энхчимэг		2,000.0	2,000.0	2,000.0	6,000.0	хуулийн хугацаа дууссан
15	RUSS_16/20	248	5/18/2012	Наймаанчин, Оросын эзэнт гүрний үеийн эдийн засгийн чөлөөт бусийн дүр төрх, түүх, орчин үе, хэтийн төлөв	2012	2014	НСИС ОУХ	6,000.0	Б.Энхтүвшин		2,000.0	2,000.0	2,000.0	6,000.0	хуулийн хугацаа дууссан
16	RUSS_17/20	248	5/18/2012	Баруун монголчуудын шарын шашны өв: аман болон бичгийн уламжлал	2012	2014	ТүүХ	6,000.0	Ц.Энхчимэг		2,000.0	2,000.0	2,000.0	6,000.0	хуулийн хугацаа дууссан
17	RUSS_27/12	248	5/18/2012	Баруун монголын ард түмнүүдийн хэлний сэтгэлгэн дэх Орос, Монгол соёлын онцлогтой үгс	2012	2014	Ховд ИС	6,000.0	Б.Энхжаргал		2,000.0	2,000.0	2,000.0	6,000.0	хуулийн хугацаа дууссан
18	20/12	163	4/10/2012	Уураг, энергийн агуулмаж ихтэй биологийн идэвхит тээвэрлэлтийн технологи	2012	2014	С	81,213.0	Н.Тогтохбаяр		27,071.0	27,071.0	27,071.0	81,213.0	ХХАА-д хүлээгдэж байгаа
19	21/12	163	4/10/2012	Монгол адууны ашиг шинийг нэмэгдүүлэх удам зүйн үндэслэл	2012	2014	ШХ	107,142.4	Л.Даваахүү		77,142.4	-	30,000.0	107,142.40	ХХАА-д хүлээгдэж байгаа
20	23/12	163	4/10/2012	Монголын хүн амын хүнсний бодит хэрэглээний судалгаа	2012	2014	С	106,823.0	Ц.Одбаяр		38,032.0	30,000.0	38,791.0	106,823.0	ХХАА-д хүлээгдэж байгаа
21	24/12	163	4/10/2012	Абиотик стресс тэсвэртэй төмсний селекцийн эх материал гаргах, үр үржүүлэх	2012	2014	ЭШХ	86,220.3	Х.Оргодол		56,220.3	-	30,000.0	86,220.30	ХХАА-д хүлээгдэж байгаа
22	26/12	163	4/10/2012	Боловсруулж давуу шинж чанартай бүтээгдэхүүний технологи	2012	2014	НэхХ	119,135.0	Д.Энхтүяа		44,082.9	-	18,500.0	62,582.90	АУЯ-д хүлээгдэж байгаа
23	27/12	163	4/10/2012	Малын будагч ноосны хялгаслаг ширхэгт болон дамжлагын хаягдлыг боловсруулах шинэ технологи	2012	2014	С	104,511.0	Г.Ганбат		32,032.0	39,207.0	33,270.0	104,509.0	АУЯ-д хүлээгдэж байгаа
24	28/12	163	4/10/2012	Арьс шир боловсруулах үйлдвэрийн хаягдал усны лагийг дахин боловсруулах шинэ технологи	2012	2014	С	117,607.0	Т.Төрмөнх		36,032.0	44,103.0	37,472.0	117,607.0	АУЯ-д хүлээгдэж байгаа

25	29/12	163	4/10/2012	Ургамлын гаралтай түүхийг эд ашиглан биологийн идэвхит хүнсний нэмэлт гарган авах технологийг дулаан солилцооны тоног төхөөрөмжийн элэгдэл, зэрвэлт, бөлгөрлөлийн судалгаа	2012	ХААИ С	90,000.0	Б.Одгэрэл	27,568.0	33,743.0	28,689.0	90,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
26	31/12	163	4/10/2012	Монгол орны ургамлын түүхийг эдийн бэлдмэлийг ашиглан буюуцелезын эмчилгээг боловсронгуй болгох	2012	ХААИ С	131,969.0	Б.Оюунсүвд	40,432.0	49,489.0	42,048.0	131,969.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
27	35/12	163	4/10/2012	Тарваган тахал, хууриар сүрьеэгийн үүсгэгчийг оношлох нан залуур хуурашуулах	2011	ХААИ С	125,103.0	Р.Оюунгэрэл	36,032.0	41,103.0	44,968.0	122,103.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
28	IN_10/2011	187	5/23/2011	Эх орны түүхийг эд ашиглан шил, шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи	2011	ХААИ С	90,078.0	А.Эрдэнэба	79,257.3	6,354.6	4,388.0	89,999.9	УХААЯ-д хүлээгдэж байгаа
29	CT_01/2011	523	12/15/2011	Малын тэжээлийн ургамлын шилмэл сорт гаргах, тариалах, үйлдвэрлэх технологи	2011	ХААИ С	495,500.0	П.Алтанцог	200,020.0	240,000.0	55,476.0	495,496.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
30	CT_02/2011	523	12/15/2011	Цөлжилтийг сааруулах технологи	2011	ХААИ С	496,440.0	Н.Тогтохбая	185,500.0	210,000.0	100,900.0	496,400.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
31	CT_03/2011	523	12/15/2011	Усыг эргүүлэн ашиглах технологи	2011	ХААИ С	428,700.0	Ж.Цогтбаат	157,900.0	112,900.0		270,800.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
32	CT_04/2011	523	12/15/2011	Цөлжилтийг сааруулах технологи	2011	ХААИ С	320,280.0	Д.Басандор	109,800.0	109,800.0		219,500.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
33	RUSS_06/2012	248	5/18/2012	Усны эргүүлэн ашиглах технологи	2012	ХААИ С	9,000.0	Р.Батмэнд	3,000.0			3,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
34	IN_01/2012	243	5/17/2012	Хүнсний ногоо боловсруулах, технологийн үйлдвэрлэл	2012	ХААИ С	77,000.0	Д.Долгорна	85,000.0	4,300.0	7,700.0	77,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
35	IN_10/2012	243	5/21/2012	Хүнсний эсрэг идэвхтэй Талимон шинэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	2012	ХААИ С	84,000.0	Д.Сэлэнгэ	61,100.0	15,440.0	7,460.0	84,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
36	IN_12/2012	243	5/23/2012	Чингис хааны өлгий нутгийн түүх, археологийн дурсгалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох нь	2012	ХААИ С	70,000.0	Б.Цогтбаата	36,300.0	25,500.0	8,200.0	70,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
37	Doc_06/2013	220	6/11/2013	Монгол орны усны бохирдлын математик загварчлалын судалгаа	2013	ХААИ С	10,000.0	Ж.Янжмаа		5,000.0	5,000.0	10,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
38		231	6/14/2013	Уламжлалт анагаах ухааны тулгуур бүтээлүүд	2013	ХААИ С	38,000.0	Ш.Болд		34,200.0	3,800.0	38,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
39		231	6/11/2013	Монгол Улсын 1-8 настай хүүхдийн хар тугалганы хордлогын анализ	2013	ХААИ С	83,600.0	Ө.Ганчимэг		25,000.0	50,600.0	75,600.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
40		231	6/11/2013	Стратегийн хүнсний биотехнологийн үйлдвэрлэл хөгжлийн загвар бус сүүний инновацийн төсөл	2013	ХААИ С	80,000.0	Ц.Цэцэгдэм		25,000.0	55,000.0	80,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
41		261	7/1/2013	Малчин өрхийн үйлдвэрлэлийн цогцолбор асуудлуудын шийдлийг ойролцоолон олох аргуудын автоматжуулалт	2013	ХААИ С	80,000.0	Б.Дагдэмбэрэл		50,000.0	30,000.0	80,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
42	13-01-92200	267	7/4/2013	Гүдгэр бнш бутархай програмчлалын борлогын онол, алгоритм	2013	ХААИ С	8,000.0	Б.Очирбат		4,000.0	4,000.0	8,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
43	13-01-92201	267	7/4/2013	Бэлгийн замаар дамжин халдаарлах вируст халдварын тархалт, сэргийлэх арга	2013	ХААИ С	8,000.0	Р.Энхбат		4,000.0	4,000.0	8,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
44	SHUT_020/2013	349	9/10/2013	Монгол Улсын түлш, эрчим хүчний нэгдсэн баланс түүний шинжилгээ	2013	ХААИ С	30,000.0	П.Нямдаваа		15,000.0	15,000.0	30,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
45	SHUT_025/2013	349	9/10/2013	Байгалийн аялал жуулчлал уулархаг бүс нутгуудын тогтвортой хөгжлийн хүчин зүйл болох нь	2013	ХААИ С	42,000.0	Б.Нүүрэл		14,000.0	28,000.0	42,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
46	14-22-03003	196	5/9/2014	Харангын голын хуучин чулуун зэвсгийн үеийн олон соёлт давхаргын археологийн судалгаа	2014	ХААИ С	4,600.0	Д.Нар-Од			4,554.0	4,554.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
47	14-21-03551	196	5/9/2014	Соёлт давхаргын археологийн судалгаа	2014	ХААИ С	2,000.0	Б.Гүнчинсүрэн			2,000.0	2,000.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
48	IN_03/2013	457	12/16/2013	Болсвсрол, шинжлэх ухааны салбар үр дүнд суурилсан санхүүгийн механизмыг ашиглах нь	2013	ХААИ С	97,980.0	Х.Эрдэнэчул		78,140.0	19,840.0	97,980.0	УХААЯ-д хүлээгдэж байгаа
48				Нийт дүн			4,301,261.7		222,700.0	1,137,064.6	915,767.0	3,855,806.3	

ШУТС-ийн 2014 оны Захац ажлын төлбөрийн үлдэгдэл													Хавсралт № 2		
д/д	Төслийн нэр	Эхлэх өдөр	Дуусах өдөр	Гүйцэтгэгч байгууллага	Урьдагч	Авсан зээл, хүү			Төлбөлт			Нийт төлбөлт	Үлдэгдэл	Сүүлд хүү нэмсэн	
						Үндсэн зээл	хүү	Нийт	2012 оноос өмнө	2013 онд	2014 онд			Сүүлд тооцсон хүү	Сүүлд хүү нэмсэн
1	Ховор ургамал өсгөн үржүүлэх	2002	2005	Ботаникийн хүрээлэн	Х. Дашбалдан	15,000,000.00	1,800,000.00	16,800,000.00				0.00	16,800,000.00	4,100,000.00	20,900,000.00
2	Барилгын өнгөлөөний тоосго хөнгөрүүлсэн бүтэц үйлдвэрлэх цех	2003	2008	"Олон хүндэд" ХХК	З. Батшандас	20,000,000.00	3,600,000.00	23,600,000.00				0.00	23,600,000.00	6,600,000.00	30,200,000.00
3	Гуулингийн усалгаатай талбайд чихэр өвс, монгол хүнчир, тариагжуулах /Монгол плантация /	2003	2006	Эксплант ХХК	Н. Төмөрхуяг	40,000,000.00	7,200,000.00	47,200,000.00	7,500,000.00			7,500,000.00	39,700,000.00	15,200,000.00	54,900,000.00
4	Бактормадипон үйлдвэрлэх цех	2006	2009	Монгол амь ахуйн шинжлэх ухааны	Н.Энхболд	25,000,000.00	1,500,000.00	26,500,000.00	3,000,000.00			3,000,000.00	23,500,000.00	7,500,000.00	31,000,000.00
5	Могойн хорноос шинэ нэр төрлийн био-бэлдмэл үйлдвэрлэх	2006	2008	Монгол амь ахуйн шинжлэх ухааны	Э.Амар	50,000,000.00	6,000,000.00	56,000,000.00				0.00	56,000,000.00	10,000,000.00	66,000,000.00
6	Чацарганы суулгац үржүүлэх	2006	2008	"Увс трейд" ХХК	Х. Цэвгээ	7,500,000.00	900,000.00	8,400,000.00	6,300,000.00			6,300,000.00	2,100,000.00	2,250,000.00	4,350,000.00
7	Бүхэл үлдэцийг Finger joint мебелийн цэвэршүүлсэн хавтангийн үйлдвэрлэл з/б	2007	2010	ШУТИС-ийн Ой модны сургалт	Н. Долгорхүү	30,000,000.00	4,050,000.00	34,050,000.00	22,429,439.00		7,570,561.00	30,000,000.00	4,050,000.00	6,200,000.00	10,250,000.00
8	Жижиг үйлдвэрлэлийн технологийн процессийг хянах, удирдах микро-	2007	2010	"Мандал" ХХК	Ц. Энхмандал	20,000,000.00	2,940,000.00	22,940,000.00				0.00	22,940,000.00	3,800,000.00	26,740,000.00
9	Ухрийн цусан халдвараас сэргийлэх	2007	2010	Мал эмнэлгийн хүрээлэн	З. Батсүх	30,000,000.00	3,960,000.00	33,960,000.00	9,300,000.00		7,700,000.00	17,000,000.00	16,960,000.00	7,200,000.00	24,160,000.00
10	Булдай шинэ сортын үр үржүүлэг	2008	2011	ХААИС-ийн эрдэм шинжилгээний сургалт	Л. Даваа	20,000,000.00	2,680,000.00	22,680,000.00	2,000,000.00		4,000,000.00	6,000,000.00	16,680,000.00	2,600,000.00	19,280,000.00
11	Айрагны ган хөхүүр АГХ төхөөрөмжийг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх	2008	2011	Шинэ зүг ХХК	Д. Батжаргал	15,000,000.00	2,015,000.00	17,015,000.00	510,000.00			510,000.00	16,505,000.00	2,700,000.00	19,205,000.00
12	Ус өргөх ороомогт насос үйлдвэрлэх	2008	2011	"Экс паб" ХХК	З. Олбоо	10,000,000.00	1,145,000.00	11,145,000.00	5,500,000.00			5,500,000.00	5,645,000.00	1,800,000.00	7,445,000.00
13	Төмөр бетон ханыг хавтгайлж, ашиглан угсармал аргаар туршилтын загвар байшин барьж турших.	2009	2011	Степсолар ХХК	П.Цагаан	80,000,000.00	7,200,000.00	87,200,000.00				0.00	87,200,000.00	4,600,000.00	91,800,000.00
14	Хуурай сүү үйлдвэрлэх төсөл	2010	2013	ШУА-ийн Технологийн Инкубатор	Ч.Батсүх	50,000,000.00	7,600,000.00	57,600,000.00	3,000,000.00			3,000,000.00	54,600,000.00	3,000,000.00	57,600,000.00
15	Байгалийн хөрлөлттэй мөсөн зорь	2010	2013	ШУА-ийн ГЗ хүрээлэнгийн	Я.Жамбалжав	60,000,000.00	9,300,000.00	69,300,000.00	5,400,000.00		20,000,000.00	25,400,000.00	43,900,000.00	2,229,818.31	46,129,818.31
16	сүүний үхэр сүүрийн импортлогч орлох бүрэн найрлагат тэжээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	2011	2014	Замбатив ХХК	Д. Эрдэнэчимэг	45,000,000.00	6,600,000.00	51,600,000.00				0.00	51,600,000.00		51,600,000.00
17	Тэжээлийн олон наст ургамлын үр үржүүлэг	2012	2015	МААЭШХ	Ц.Дэкирмаа	44,000,000.00	6,540,000.00	50,540,000.00		3,000,000.00	3,640,000.00	6,640,000.00	43,900,000.00		43,900,000.00
18	Ургамлын гаралтай бэлдмэлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх	2012	2015	УХЭШХ	Х.Батнаран	85,000,000.00	11,985,000.00	96,985,000.00		10,000,000.00		10,000,000.00	86,985,000.00		86,985,000.00
19	Тахианы тэжээлийн үйлдвэрлэлийн төсөл	2012	2015	ШУТИС	Д.Эрдэнэчимэг	50,000,000.00	7,680,000.00	57,680,000.00				0.00	57,680,000.00		57,680,000.00
	Нийт дүн			Дүн		696,500,000.00	94,895,000.00	791,395,000.00	64,939,439.00	13,000,000.00	42,910,561.00	120,850,000.00	670,545,000.00	79,779,818.31	750,324,818.31



2015 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 337

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5 дахь заалт, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:


1. "Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын явцад илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Зам тээврийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол соёл, шинжлэх ухааны яаманд тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2016 оны 06 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам тээврийн сайд, Эрүүл мэнд, спортын сайд, Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд, Шинжлэх ухаан технологийн сангийн захирал нарт зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга /Б.Алтанзул/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Tushaai\2015\1223NAG1.Docx



Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

№	Байгуул агын нэр	Төлбөр, зөрчил хармудогчийн		Төлбөр, зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Ахтын дугаар	Төлбөр, зөрчлийн дүн /tenge/
		Нэр	Албан тушаал				
1	БСШУЯ	Ш.Булга-Эрдэнэ	Төрийн нэрийн бичгийн дарга	Соёл, урлаг, хөгжүүлэх санд шилжүүлэх тогтоолын орлогыг төвлөрүүлээгүй		1/31 ҮАГ- НАГ/2015/04-НА	2,973,840
2	"Хас" урлаг- студиа	С.Өлзийхүү	Гүйцэтгэх захирал	Соёл, урлаг, хөгжүүлэх санд шилжүүлэх тогтоолын орлогыг төвлөрүүлээгүй		1/32 ҮАГ- НАГ/2015/04-НА	4,000,000
3	ШУТС	Х.Дондог	Захирал	Сангийн хөрөнгийг зорцуулалт бусаар зарцуулсан		1/34 ҮАГ- НАГ/2015/04-НА	4,473,000
4	ЭМСЯ	Н.Бат-Эрдэнэ	Төрийн нэрийн бичгийн дарга	Төсвийн төлөвлөлийг болгосонгүй болгох үр ашгийг дээшлүүлэх	2/134 ҮАГ/НАГ/2015/0 4-НА		
5	БСШУЯ	Ш.Булга-Эрдэнэ	Төрийн нэрийн бичгийн дарга	Зөрчил арилдуулах тухай	13/136 ҮАГ/НАГ/2015/0 4-НА		1,264,400,000
Нийт дүн							1,275,846,840

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР